MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,130.595... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.02.07. Мягмар. №025 (4639) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




ОНЦЛОХ ХУУДАС

ДАВАРСАН ИМПОРТЛОГЧДЫГ ДАРАХ ЦАГ НЬ БОЛСОН БАЙЛТАЙ

V нүүрт

ЗАСАГ ДАРГА ЯРЬЖ БАЙНА

III.ОРГИЛ: ХИЙЕ, БҮТЭЭЕ ГЭСЭН ХЭНИЙГ Ч ДЭМЖИЖ АЖИЛЛАНА

VI-VII нүүрт

Дугаарын 60 мөр

## Антибиотекийн анагаах хөг өнгөрөх нь

Н.БАТЗАЯА

Хүн гэдэг амьтан энэ хорвоо дээр үр, удмаа үлдээж, тэднийхээ сайн сайхны төлөө амиа өгөхөөс ч буцдаггүй. Гэхдээ үр, хүүхдийнхээ төлөө бүхнийг хийнэ гээд өөрийнхөө гараар хүүхэддээ хор уулгаж буйг анагаахын салбарын эрдэмтэд өдөр бүр бидэнд сануулж байна. Гэхдээ энэ аймшигтай бөгөөд харамсалтай үзэгдэл манай улсад их байгаа гэдгийг онцолъё. Энэ бүхэн зөвхөн та бидний хариуцлагагүй, хэнэггүй зангаас болж эдүгээг хүртэл оршин буй билээ. Учир гэвэл манай улсын захын нэг эмийн санд "Хүүхэд маань ханиалгаад байна ямар эм авбал зүгээр вэ" гэх эцэг, эхийн асуултад "Хий ханиалгаж байна уу, цэр гарсан уу.

Төгсгөл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

# Үсан идсэнээ биш БАТАЛСАН ХУУЛИА ТАЙЛБАРЛААЧ ЭЭ

–НӨАТ–ын хуулийг тайлбарласан бол 80 биш 800 мянган хүн буцаалт авах байсан бус уу–




Б.ӨНӨРТОГТОХ

Цахим хуудаснаа нэгэн залуу эрүүл мэндийн даатгал төлсөн мөнгөөрөө ганцхан эмнэлгийн үйлчилгээ авдаг бус спорт заал, фитнесс төвүүдээр үйлчлүүлэхдээ хөнгөлөлт эдэлдэг байх тухай санаачилга гаргажээ. Энэ санаачилга олон ч хүмүүсийн дэмжлэг авч, зөв зүйтэй санал учраас хуульд тусгах тухай яриа гарав. Гэтэл эрүүл мэндийн үйлчилгээнээс гадна өөр бусад хөнгөлөлт эдлэх зүйл заалт Эрүүл мэндийн яамнаас оруулж ирсэн хуульд хэдийнэ тусгагдсан бөгөөд УИХ-аар хэлэлцэж эхэлчихээд байгаа аж. Харин иргэд энэ талаар ямар ч мэдээлэлгүй учраас аргаа барахдаа цахим орчинд бичиж, санаа оноогоо уралдуулж суугаа нь тэр л дээ. Энэ бол энгийн нэг жишээ.

Өнгөрсөн парламентад сүр дуулиантайгаар батлагдсан Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг ч иргэд өнөө хэр сайн ойлгоогүй л яваа. Тиймээс төрд төлсөн даатгалаа хэрхэн юунд зарцуулахаа мэдэхгүй хувийн төлбөртэй эмнэлэг бараадаж яваа нь худлаа биш. Замын хөдөлгөөний тухай шинэ хууль хэрэгжиж эхэлсэн даруйд цагдаагийн албаны эх сурвалж торгууль төлж буй жолооч нарын ихэнх нь хуулиа уншиж судлаагүйгээс дүрэм зөрчдөг тухай ярьсан байсан юм. Гэтэл эдгээр жолооч нарт хууль уншаагүй учраас өршөөл үзүүлэх бус харин ч хуулиа уншиж судлаагүй хэмээн давхар хариуцлага ноогддог гэнэ. Хуулиа мэдэхгүй, уншаагүй яваа нь мэдээж жолооч нарын буруу. Гэхдээ хуулийг хаанаас унших вэ, хэнээс мэдээлэл авах вэ гэдэг асуулт яах аргагүй урган гарч байгаа биз. УИХ-ын чуулганаар ямар хууль батлагдаж байгааг иргэд нэгбүрчлэн мэдэх боломжгүй.

Үргэлжлэл нь III нүүрт

ӨӨРӨӨС НЬ

# Д.ОЮУНХОРОЛ: ХЯТАДЫН ЖУУЛЧДЫГ ВИЗЭЭС ЧӨЛӨӨЛӨХГҮЙ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Ж.МЯГМАР

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр өнгөрсөн долоо хоногоос хятад жуулчдыг визгүй зорчуулах нь гэсэн мэдээлэл цацагдаж эхэлсэн. Тэгвэл үүнтэй холбоотойгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ.

Аялал жуулчлалын салбарт эдүгээ 54 мянган хүн ажиллаж байна. Өнгөрсөн жил Монгол Улсад 404 мянган жуулчин ирж, эдийн засагт 312 сая ам.долларын орлого оруулжээ. Гэвч энэ нь хангалттай үзүүлэлт биш, жил ирэх тусам Монголд ирэх жуулчны тоо буурч байгаа аж. Ингэхдээ Монголд ирэх хятад жуулчдын тоо улам бүр буурах болжээ. Жуулчдын тоо нэмэгддэггүй нь нэгдүгээрт, визний асуудал маш хүндрэлтэй, интернэтээр виз захиалж, авч болдоггүй.

Төгсгөл нь II нүүрт

ДЭЛХИЙ

# МЕЛАНИ ТЭРГҮҮН ХАТАГТАЙН УЛАМЖЛАЛЫГ ЭВДЭХ ҮҮ

Б.ДАВАА

Үл хөдлөх хөрөнгийн салбарт өөрийн нэрээ тамгалж чадсан тэрбумтан Доналд Трамп АНУ-ын Ерөнхийлөгч болж, тангаргаа өргөснөөс хойш хоёр долоо хоног өнгөрчээ. Гэвч энэ хугацаанд эдүгээ 46 настай Мелани Трамп ямаршуу тэргүүн хатагтай болж, түүхэнд тэмдэглэгдэх вэ гэдэг талаар таамаг, эргэлзээ хосолсоор байна. Нэгэн цагт загварын тайзнаа алхаж явсан Мелани Трамп нөхрийнхөө тангараг өргөх ёслолын үеэр Ральф Лорены урласан усан цэнхэр өнгийн, харин оройн үдэшлэгт цагаан өнгийн мөр ил гарсан даашинзаар гоёсон бөгөөд түүний загварын мэдрэмж тухайн үедээ л олны ярианы сэдэв болж байсан юм. Д.Трамптай гэрлэж, нэг хүүхэд төрүүлсэн тэрбээр шинэ үүрэг хариуцлагад алхам урагшлах хүсэл эрмэлзлэл дүүрэн байгаа нь эндээс харагдаж байлаа.

Төгсгөл нь IV нүүрт




**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2470.00 | 2484.00 | ФУНТ | 3038.00 | 3142.00 |
| ЕВРО | 2634.00 | 2704.00 | РУБЛЬ | 40.30 | 43.30 |
| ИЕН | 21.79 | 22.12 | ЮАНЬ | 360.00 | 365.20 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2472.00 | 2482.00 | ФУНТ | 3068.00 | 3148.00 |
| ЕВРО | 2646.00 | 2716.00 | РУБЛЬ | 40.79 | 43.86 |
| ИЕН | 21.82 | 22.42 | ЮАНЬ | 360.00 | 365.00 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## Усан замын тээврийн тухай хуулийг анхны хэлэлцүүлэгт шилжүүллээ

Монгол Улсын Засгийн газраас 2016 оны арванхоёрдугаар сарын 28-нд УИХ-д өргөн мэдүүлсэн "Усан замын тээврийн тухай" хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал болон холбогдох бусад хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороонд өнгөрсөн баасан гарагт хэлэлцсэн билээ. Уг хууль 2003 онд анх батлагдсан бөгөөд сүүлийн жилүүдэд дотоодын аялал жуулчлал хурдацтай хөгжиж буйтай холбоотойгоор амраг, аялагчид Монгол орны томоохон гол, мөрөн, нуурын эрэг орчимд амарч зугаалах нь ихсэх болсон. Үүнтэй зэрэгцэн бага оврын усан замын тээврийн хэрэгслээр аялал жуулчлалын зориулалттай зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн тоо жил ирэх тусам нэмэгдэж, түүгээр үйлчлүүлэх иргэдийн тоо өсөн нэмэгдэхийн хэрээр хүний амь, нас эрсдэх явдал буурахгүй байна. Үүний шалтгаанд усан замын тээврийн хяналтын тогтолцоо сул, газар дээр нь улсын хяналтыг хэрэгжүүлэн ажиллах хүн хүчний хүрэлцээ хангалтгүй байдаатай холбон тайлбарлаж болох ээдий ч цаашид тус салбарын эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох, салбарын боловсон хүчний нөөцийг бэлтгэх шаардлагын үүднээс хуулийн төслийг анх боловсруулсан аж. Түүнчлэн хуулийн төсөлд тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах, усан замын тээврийн хэрэгслийн техникийн ашиглалт, үйлчилгээний чанар, хүртээмж, хөдөлмөр хамгаалалд тавих хяналт сайжирна гэж төсөл санаачлагч Зам, тээврийн хөгжлийн яамнаас үзэж байгаа юм байна.

MMINFO.
МОНГОЛЫН МЭДЭЭ
19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч:
С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч
Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:
Э.ЭНХЦЭЦЭГ
90873012

Ахлах редактор:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба
Н.ПУНЦАГБОЛД
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Гэрэл зургийн алба:
Г.АРГУУЖИН
96017873

Компьютерийн алба:
Б.ГАНЗОРИГ
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба:
Н.АЛТАНЦЭЦЭГ
99173710

Захиалга, борлуулалтын алба:
М.ДАВААДУЛАМ
99042510

Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхэлсэн
Б.ДАВААХҮҮ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.
2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс:
976-70113551

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ХААЛТТАЙ ХУРАЛДААНААС



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## С.ЭРДЭНЭ: ЗАСГИЙН ГАЗРЫН 200 ДАХЬ ХОНОГТ АН-ЫН БҮЛЭГ ДҮН ТАВИНА

Ж.ОТГОН

УИХ дахь АН-ын бүлгийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлын талаар мэдээлэл хийлээ. Энэ удаагийн хэвлэлийн хурлад АН-ын бүлгийн дарга С.Эрдэнэ, дэд дарга Б.Пүрэвдорж нар оролцлоо. Хурлаар Эрүүгийн болон Зөрчлийн хууль, бусад гэсэн асуудлын хүрээнд зарим асуудлыг ярилцсан байна. Энэ талаар тус бүлгийн дарга С.Эрдэнэ "Эрүүгийн болон Зөрчлийн хуульд шинэчлэн найруулгын хэмжээнд өөрчлөлт оруулж байгаатай холбогдуулан мэргэжлийн хүмүүс болон ХЗДХЯ-ны удирдлагуудаас мэдээлэл авлаа. Зөрчлийн тухай хуулийн хэрэгжих хугацаа нь ирэх долдугаар сарын 01-н байгаа. Зөрчлийн тухай хуулийн үндсэн үзэл санаанд өөрчлөлт ороогүй, техникийн шинжтэй үг, үсэг, зүйл заалтын тайлбар зэрэгт өөрчлөлт орж байгаа гэсэн тайлбар өгсөн. Эрүүгийн хуулийн 40 орчим хувьд нь өөрчлөлт орж байгаа юм байна.

Мөн л техникийн чанартай өөрчлөлт орж байгаа гэсэн мэдээллийг бидэнд өгсөн. Бидний зүгээс Эрүүгийн, Зөрчлийн хуулийг нэгтгээд иргэд болон хуульчдад зөв ойлгогдох талаас нь нээлттэй хэлэлцүүлэг явуулах нь зүйтэй гэсэн бүлгийн дүгнэлт гарган ХЗДХЯ-ны удирдлагад тавихад боломжтой гэсэн хариу өгсөн" гэлээ. Эрүүгийн, Зөрчлийн хууль заасан зорчих эрхийг хязгаарлах зүйл заалттай холбоотойгоор хэрэгжүүлэх боломжгүй байна гэсэн үндэслэлийг хэлсэн. Эрүүгийн хуульд хорих доод хугацааг долоо хоног байснаа зургаан сар болгон өөрчилж байгаа. Торгуулийн хэмжээгээр зохицуулах замаар доод хэмжээг зургаан сар болгож байгаа нь хөрөнгө мөнгө хэмнэж, хоригдох хүний тоо эрс багасна гэж үзэж байгаагаа танилцуулсан юм байна.

### Л.Гансүхийн асуудлаар прокурорт хүсэлт хүргүүлнэ гэв

Бусад гэсэн асуудлын хүрээнд УИХ-ын гишүүн асан Л.Гансүхийн хоригдож байгаатай холбоотой асуудлыг бүлгээр хэлэлцсэн байна. Энэ талаар АН-ын бүлгийн дарга С.Эрдэнэ "Л.Гансүхийн өмгөөлөгчөөр дамжин АН-ын бүлэгт захидал ирсэн. Уг захидалд Л.Гансүхийн хоригдох хугацаа дуусссан, өр төлбөрөө барагдуулсан, гурван удаа прокурорт хандсан ч хоёр удаа буцаасан байгаа юм байна. Гэр бүлийн хүн нь хүнд өвчтэй байгаа зэрэг олон шалтгааныг дурьдсан байгаа. Бид бүлэг дээр ярилцаад бүлгийн гишүүд УИХ-ын гишүүнийхээ хувиар гарын үсэг зурж Улсын Ерөнхий Прокурорт хүсэлт хүргүүлэх шийдвэр гаргасан. Бүлгийн улс төрийн албан ёсны байр суурийг одоогоор илэрхийлэх боломжгүй гэж үзсэн учир гишүүдийнхээ хувиар Ерөнхий прокурорт хандахаар боллоо" гэсэн юм.

Түүнчлэн Засгийн газрын 200 дахь хоногийн дүнг авч хэлэлцэхээр болсон гэнэ. Учир нь Засгийн газар байгуулагдаад 200 дахь хоногтоо ажил нь явагдаад дуусч байгаа. Тиймээс энэ хугацаанд юу хийсэн, улс орны эдийн засагт ямар өөрчлөлт гарсан зэрэгт дүгнэлтээ гаргахаар болсон байна. Тиймээс энэ сарын 13-ны өдөр буюу даараагийн бүлгийн хурлаар Засгийн газрын 200 дахь хоногийн ажлын дүнг авч хэлэлцээд олон нийтэд албан ёсны байр суурия илэрхийлэх юм байна.

ӨӨРӨӨС НЬ

## Д.ОЮУНХОРОЛ: ХЯТАДЫН ЖУУЛЧДЫГ ВИЗЭЭС ЧӨЛӨӨЛӨХГҮЙ

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Заавал Элчин сайдын яам, Дипломат төлөөлөгчийн газарт хандах шаардлагатай болдог. Хоёрдугаарт, агаарын тээврийн үнэ өндөр, олон улсын зах зээл дээр аялын бүтээгдэхүүн зарлагдсаны дараа нислэгийн үнээ зарладаг. Гуравдугаарт, жуулчны бүтээгдэхүүний нэр төрөл цөөн байгаа зэрэг нь аялал жуулчлалыг хөгжүүлэхэд бэрхшээл учруулж байгаа аж. Иймээс салбар яамнаас эдгээр асуудлыг хэрхэн шийдвэрлэх бодлого боловсруулж, ажиллаж байгаагаа УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд мэдээлсэн. Үүнийг буруу ташаа ойлгосон учраас бодитой мэдээлэл өгөх шаардлага гарлаа гэдгийг салбарын сайд онцолж байлаа.

*Үүний дараа сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулт өглөө.*

**-Эдийн засгийн байнгын хорооны хуралдааны үеэр та Хятадын жуулчдыг визгүй оруулна гэх утга бүхий асуудлыг хөндөж ярьсан талаархи дүрс бичлэг цахим орчинд түгсэн. Хятад жуулчдыг нэвтрүүлэх бол хөнгөлөлт үзүүлэх юм уу, эсвэл визгүй болгох асуудал дээр ойлголцохгүй байгаа юм уу?**

-Аялал жуулчлалын салбарт хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх шаардлагатай байна гэдгийг аймаг, орон нутгийн удирдлагууд Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хэрэв хийхдээ санал болгож байгаа. Дорнодын хилээр орж ирээд Дорнод аймгийг үзэх жуулчид Улаанбаатарт ирж виз авдаг хүнд сурталтай байж болохгүй. Тийм учраас бүлэг жуулчдыг орж ирэхэд нь визний хөнгөлөлт үзүүлэх талаар Гадаад харилцааны яам манай яамтай хамтран ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа. Эдийн засгийн байнгын хороны хуралдаан дээр яг ингэж хариулсан. Хөнгөлөлтийг яаж үзүүлэх вэ гэдэг дээр онцгой анхаарах. Бүлэг жуулчин гэдэг аялал жуулчлалын мэргэжлийн байгууллагаар дамжин, нарийн зохион байгуулалттай орж ирдэг хяналтын тогтолцоотой юм. Нөгөө талаас Монгол Улсад Хятад улсын иргэнийг визгүй зорчих асуудлаар ямар ч шийдвэр гараагүй. Ингэж монголчуудыг талцуулан хуваах, нөгөө талдаа гадаад харилцаандаа маш эмзэг сэдвийг мэдээллийн хэрэгслээр цацаж байгааг нь буруу гэж боддог. Үүнийг олон нийт ч, хууль хяналтын байгууллага ч анхааралтай харж байгаа байх. Бүлэг жуулчин оруулж ирэхгүйгээр Монголын аялал жуулчлал хөгжүүлэх боломжгүй гэдэг нь ийм учиртай.

**-Бүлэг жуулчин гэдэгт хэдэн хүнийг тооцож байна вэ. Жилд ирдэг жуулчдын хэдэн хувь нь бүлгээрээ ирдэг юм бэ?**

-2013 оноос эхлэж бүлэг жуулчинд хил орчмын аялал жуулчлалын үнэмлэх олгоод нэвтрүүлсэн байдаг. Нэг удаагийн зориулалттай үнэмлэх олгодог. Энэ үнэмлэхээр ОХУ, Мьянмар, Вьетнам, Лаос, Хойд Солонгос зэрэг орнуудад зорчих боломжтой гэж Хятадууд өөрсдөө тодорхойлсон байгаа. Манай улсын хувьд 15-30 хүртэлх хүний тоонд байгааг бүлэг жуулчид гэж үздэг. Визгүй зорчуулах тухай асуудал байхгүй. Хамт ирсэн жуулчдаас нэг хүн л байхгүй бол бүлэг жуулчдыг бүхэлд нь гаргахгүй. Өөрөөр хэлбэл, 15 хүн орж ирчихээд 14-үүлээ гарах гэвэл нэг хүнээ олж ир гээд хилээр гаргахгүй, зогсоочихно. Энэ бол хатуу шалгууртай, шаардлагатай үйл ажиллагаа. Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Замын-Үүдийн шалган нэвтрүүлэх боомтоор 2015 онд 13900 хятад жуулчид аялсан байдаг. Энэ үнэмлэхээр нэвтэрч байсан жуулчдыг 2016 оны хоёрдугаар сараас зогсоосон. Монголд АСЕМ-ын уулзалт болохтой холбоотойгоор энэ үед дээрх шийдвэр гаргаж зогсоосон юм билээ. Энэ асуудлыг сэргээх тухай асуудлыг л ярьж байгаа, шинэ зүйл биш.

**-Таны ажлын байрандаа гитар тоглож байгаа зураг олон нийтийн сүлжээгээр цацагдлаа. Үүнд тайлбар хийх үү?**

-Би энэ зургийг гаргаж тавьсанд үнэндээ гайхсан. Тэр бол Төрийн ордны албан өрөө ч биш, ямны ч өрөө биш. Байгуулсан сургуульдаа охиныхоо өрөөнд ороод амсхийх зуураа гитар тоглосон. Сонгуулийн өмнө авсан зураг. Тэнд орж ирээд ямар хүн зураг авсан гэдгийг ч би мэдэхгүй байгаа. Тэнд архи, дарс уусан зүйл байхгүй. Би ядарсан үедээ ч юм уу, чөлөөт цагаараа гитар тоглох дуртай. Улстөрч боллоо гээд гитараа хэзээ ч орхидоггүй. Надад олон ч гитарын цуглуулга байдаг. Тоглох ч дуртай. Тэр өрөөнд орж ирээд зураг дарахад нь би "Битгий зураг дар" гэж гараараа хаалт хийсэн. Яг тэр хэсгийг гаргаад тавьж байгаа нь Монголд өнөөдөр хүн чанарын хэлтэрхий хаашаа явж байгаа юм, бид бие биенийгээ хэмлэж идэх аян дайнд мордсоны л нэг жишээ юм гэдэг нь саяын олон нийтийн сүлжээгээр гарсан зураг харууллаа. Би гитар барьдаггүй юм аа гэж худлаа ярихгүй. Тэгээд ч би Монголын төрд 20 жил зүтгэхдээ албан өрөөндөө архи, дарс ууж байгаагүй. Миний бие ч хүлээж авч чаддаггүй учраас хэрэглэдэггүй. Гэхдээ найз нөхөдтэйгээ суусан үедээ ижилхэн төвшинд дуугаа дуулаад хамтраад сууж чаддаг. Андуу ташаа ийм мэдээлэл цацсан хүмүүсийг би мэдэж байгаа. Зургийг тавьсан хүн нь ийм сэнсаацитай юм болно гэж бодоогүй юм шиг байна.

**-Социалаар дамжуулан бусдын нэр хүндэд халдах байдал олон гарч байна. Үүнийг цэгцлэх шаардлага байна гэж харагддаг. Засгийн газрын төвшинд асуудлыг судалж байгаа юу?**

-Хувь хүний нэр хаягтүй, фэйсбүүк, твиттер хаягаар орж дайрч доромжилдог зүйл нэлээд газар авч байна. Энэ бол Монголын оюун санаа хэр их хоосорч байгаа, эдийн засгийн хямрал гэхээсээ тархи нь илүү ядуу болж байгааг харуулсан загвар гэж боддог. Би сошиалд төдийлөн ороод бичээд, яриад хөөрөөд байдаггүй. Гэхдээ байнгын уншигч. Харахаар хэр хэмжээнээсээ хэтэрч байгаа зүйл олон харагддаг. Харин сүүлийн долоо хоногт өрнөсөн үйл явдал бол Монгол Улсын тусгаар тогтнол, эв нэгдлийг хагалан бутаргах, зохион байгуулалттай дотор нь үймүүлэх үйл ажиллагаа яваад байгаа юм биш биз дээ гэдэг болгоомжлол төрсөн. Гэхдээ урам өгөөд, итгэлтэй байгаарай гээд урам зориг өгч байсан хүмүүст талархаж байна. Энэ нийгэмд ийм хүмүүс нь олон байгаа, тийм учраас нийгэм зөв зам руугаа явчих тийм боломж бололцоо байгаа гэж хардаг. Цаашдаа хэвлэл мэдээллийнхэн та бүхэн санаачилга гаргавал би ч гэсэн Засгийн газрын гишүүний хувьд хамтран ажиллахад бэлэн байна. Өнөөдөр Монгол Улсаас өөр интернетийн замбараагүй хэрэглээтэй улс орон байхгүй.

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

## Беларусь улстай соёлын салбарт хамтарна

"Соёлын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Бүгд Найрамдах Беларусь Улсын Соёлын яам хоорондын хэлэлцээр"-т өчигдөр /2017.02.06/ БСШУС-ын сайд Ж.Батсуурь, Бүгд Найрамдах Беларусь Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд С.Чепурной нар гарын үсэг зурлаа. Хэлэлцээр байгуулагдсанаар хоёр орны соёл, урлагийн байгууллага болон уран бүтээлчид ажил хэргийн шууд харилцаа тогтоон, хамтран ажиллах боломжийг нээж байгаа юм. Тухайлбал, хоёр орны соёлын салбарын мэргэжилтнүүд, уран бүтээлчид туршлага, мэдээлэл, материал харилцан солилцох, шинжээч, мэргэжилтэн солилцож ажиллах, хамтарсан тоглолт, үзэсгэлэн, эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах зэрэг олон талт харилцааг хөгжүүлэх гарц нээгдэж байгаагаараа онцгой ач холбогдолтой.

## 137 мянга 822 иргэн мэдээллээ баталгаажуулаагүй байна гэв

Монголбанкнаас энэ сарын 01-03-нд 461 мянга 865 иргэнд 33.8 тэрбум төгрөгийн НӨАТ-ын буцаан олголт хийсэн талаар Сангийн яам болон Татварын ерөнхий газраас мэдээлэл хийлээ. Татварын ерөнхий газрын дарга Л.Зориг "Өнгөрсөн оны нэгдүгээр сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн НӨАТ-ын хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд www.ebarimt.mn цахим хуудсанд 620 мянга 409 иргэн бүртгүүлжээ. Үүнээс 482 мянга 587 нь овог нэр, данс, банкны мэдээлэл, регистрийн дугаараа бүрэн оруулж, 34.5 тэрбум төгрөгийн буцаан олголт авах эрх үүссэн. Өнгөрөгч баасан гарагт 33.8 тэрбум төгрөг буцаан олгосон бол өчигдөр 20 мянга 722 иргэний дансанд 700 сая төгрөг шилжүүлсэн. Ингэснээр мэдээллээ баталгаажуулсан иргэдийн буцаан олголт дуусах юм" гэв. Харин "www.ebarimt.mn цахим хуудсанд мэдээллээ бүрэн баталгаажуулаагүй 137 мянга 822 иргэн байгаа аж. Эдгээр хүмүүс энэ сарын 15-ны дотор овог нэр, банк, дансны дугаар болон регистрийн дугаараа оруулбал нийт нэг тэрбум төгрөг буцаан авах юм байна. Түүнчлэн өнгөрсөн оны нэгдүгээр сараас хойш 19 удаа сугалаа зохион байгуулж, нийт 3.6 тэрбум төгрөгийн азтан тодроод байгаа ажээ. Энэхүү мөнгийг бүрэн шилжүүлж дууссан гэнэ.

PHOTO NEWS



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

*УИХ-ын гишүүдийн дунд "Цэцэн түшээ" шатрын тэмцээн Төрийн ордонд боллоо. Тэмцээнийг нээж УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Цолмон, УИХ-ын гишүүн Г.Занданшатар, Монголын шатрын холбооны гүйцэтгэх захирал Б.Наранбаатар нар үг хэлж, оролцогчдод амжилт хүслээ.*

# ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын 60 мөр

## Антибиотекийн анагаах хөг өнгөрөх нь

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Энэ эмнээс авчих. Өдрийн гурваар уулгаарай" хэмээн хээв нэг хариулж зогсох эмийн санчийн энэ дүр төрх хэвийн нэг үзэгдэл болсон. Хэн ч сонссон эмч, өвчтөн хоёрын хооронд өрнөж буй мэт энэхүү харилцан ярианы дүр төрх бүр эм үйлдвэрлэгч томоохон компанийн нэрийн эмийн сангуудад хүртэл өрнөнө. Ингээд хэлэхээр миний юу өгүүлэх гэсэн минь тодорхой болох биз. Эмийг эмчийн зааваргүй хэрэглэх нь буруу гэдгийг мэддэг хэдий ч бид нүд нь балай, чих нь дүлий хүн шиг харсан ч хараагүй юм шиг явцгаадаг. Магадгүй та өнөөдөр анагаах ухааны салбар болон эрдэмтэн мэргэдэд итгэж сэтгэл амар алхаж байж болох юм. Гэхдээ сүүлийн үед дэлхийн анагаах ухаан хүртэл антибиотекийг зөв зохистой хэрэглэхгүй бол хүн төрөлхтөн 2050 он гэхэд нянгийн гаралтай өвчний эсрэг ямар ч эмчилгээгүй болно гэдгийг анхааруулж байна. Тодруулбал, дэлхийн анагаах ухааны эрдэмтэд эдүгээг хүртэл нийт 100 гаруй төрлийн антибиотек гарган авчээ. Харамсалтай нь түүний 60 төрлийг нь эсэргүүцэх чадвартай нян, вирүсүүд шинээр гарч ирсэн аж. Одоогийн байдлаар нийт 40 гаруй төрлийн антибиотекийг хэрэглэх боломжтой бөгөөд тэдгээрийг эсэргүүцэх чадвартай шинэ төрлийн нян жил бүр гарч ирсээр байгаа гэнэ. Хэрвээ хүн төрөлхтөн антибиотекийг буруу хэрэглэсэн хэвээр байвал 2050 он гэхэд нян, вирүсийн гаралтай өвчнийг эсэргүүцэх ямар ч эмчилгээгүй болно. Энэ статистик тоо баримт эрс тэс уур амьсгалтай, томуу, томуу төст өвчний гаралт өндөртэй улсад улам ойртох ч магадлалтай. Өвлийн улиралд эмнэлгийнх ор битгий хэл шал нь хүртэл ханиад хүрсэн бага насны хүүхдүүдээр дүүрдэг манайх шиг улсад антибиотекийн хэрэглээ маш чухал. Ялангуяа хууль эрхзүйн орчин нь бүрдсэн хэдий ч хэрэгждэггүй улсад энэ асуудал бүр ч хүндээр тусна. Гэхдээ энэ бүх аюулаас өөрсдийгөө болон үр, хүүхдээ хамгаалах хамгийн энгийн арга бол эмчийн жороор эм хэрэглэх гэдгийг эмч, мэргэжилтнүүд сануулж буй. Түүнчлэн манай улсын анхан шатны эмнэлэгт үзүүлэхээр ирж буй ханиадтай хүүхдүүдийн 90 гаруй хувь нь ямар нэгэн байдлаар 1-2 төрлийн хүчтэй антибиотек хэрэглэчихсэн байдаг байна.

Энэ нь тухайн өвчний нянг антибиотект дасгадаг аж. Ингэснээр антибиотекийг эсэргүүцэх чадвартай нянгууд үүсдэг байна. Энэ мэтчилэн хүүхдийнхээ төлөө хэмээн дур мэдэн эмийн сангаас авч өгсөн хүчтэй антибиотек таны хүүхдийн ирээдүйг аажим, аажмаар устгаж байна. Манай улсын иргэд дунд жор мэдэхгүй эмчээс зөвлөн үзсэн чавганц дээр хэмээн эмч нарт итгэдэггүй муу тал бий. Гэхдээ номын дууг нь сонсож, сурах ёстой зүйлийг нь сураад мэргэжлийн диплом өвөртөлсөн эмч нар таны хүүхдэд антибиотек бичиж өгөхгүй нь тодорхой. Мэргэжлийн эмчид биш хэн нэгний аманд итгэж хэлсэн болгоныг нь хүүхэддээ уулгасаар байвал таны хүүхэд эцэстээ ямар ч эмчилгээгүй болж дуусах нь. Үүнд төр засгийн оролцоо ч чухал. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өдөр, шөнөгүй гарах хүчтэй антибиотекийнхаа сурталчилгааг хязгаарлаж, ард иргэдэд чиглэсэн сургалт, сурталчилгаа явуулахгүй бол нэг л өдөр Монголчууд эмчилгээгүй болоход ойрхон болсон байна. Энэ аюул ойртсоныг захын нэг эмийн сангийн худалдагч "Эм авья" гэх асуултад "Ямар эм авах вэ" гэх ганцхан асуултаараа хариулаад өгнө. Уг нь эмийн санч нар юун түрүүнд эмчийн жор байгаа эсэхийг асууж, үүнийхээ дараа тухайн хүнд үйлчлэх ёстой. Гэтэл эмийн бизнесийн сүлжээ, төр засгийн буруу үйл ажиллагаанаас болж ард иргэд хохирсоор байна.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# Уусан идсэнээ биш БАТАЛСАН ХУУЛИА ТАЙЛБАРЛААЧ ЭЭ

**–НӨАТ–ын хуулийг тайлбарласан бол 80 биш 800 мянган хүн буцаалт авах байсан бус уу–**

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Дан ганц УИХ-ын чуулганыг кабелийн хэдэн сувгаар шууд дамжуулснаар мэдээлэл авчихдаг гэвэл ёстой үлгэр. Өдрийн цагаар ямар хууль батлагдахыг хараад сууж байгаад цаг завтай хүн өнөөгийн нийгэмд гарын таван хуруунд л багтана. Цахим орчинд байнга идэвхтэй байдаг, хаана ямар хууль батлагдсаныг хайж уншаад суудаг хэсэг бүлэг ч цөөхөн. Төрийн мэдээллийн эмхэтгэлд батлагдсан хууль бүрийг хэвлэдэг ч түүнийг захиалж уншдаг нь хэд вэ гэдгийг УИХ-ын албан тушаалтнууд ойлгох цаг болсон баймаар. Монголд хууль хэрэгжихгүй байгаагийн хамгийн том шалтгаан нь хууль сурталчлахгүй байгаа асуудал юм. УИХ-ын хавар, намрын ээлжит чуулганаар хэдэн зуун хууль батлагддаг. Нэмэлт өөрчлөлт, журам, ганц нэг зүйл заалтыг дурьдвал тоймгүй олон тоо гарна. Гэтэл эдгээр хуулийг иргэдэд тайлбарлах, ойлгуулах, ямар хууль дүрэмд хэрхэн өөрчлөлт орсон талаар мэдээлэл өгдөг, сурталчилдаг асуудал бүр таг болжээ. Өнгөрсөн парламентад хууль сурталчлах ажил ганц нэг идэвхтэй гишүүдийн ачаар хаягдахгүй явж ирсэн. УИХ-ын эмэгтэй гишүүдийн албан бус бүлэг баталсан хууль болгоноо сурталчилдаг байлаа. УИХ-ын гишүүн С.Ганбаатар, Ж.Батзандан зэрэг идэвхтэй гишүүд УИХ-д өргөн барьсан хуулиараа сурталчилгаа хийдэг байв. Ганц нэг яамдууд баталсан хуулиа идэвхтэй сурталчилдаг байсан учраас ор тас орхигдохгүй явж ирсэн. Гэтэл энэ удаагийн парламент хууль сурталчлах ажлыг тэр чигээр нь орхилоо. Эмэгтэй гишүүд бүлэг ч байгуулсангүй. Үгүй ядахдаа байнгын хороодын дарга нар ч хэлэлцэж буй хуулийнхаа талаар хэвлэлд мэдээлэл өгөхөөс татгалздаг болжээ.

Парламент бүрдээд нэг жилийн хугацаа өнгөрчихөөд байхад ганцхан С.Чинзориг гишүүн л эхчүүдэд тэтгэмж олгох тухай хуулийн төслийг хэвлэлийн хурал хийж тайлбарлав. Үүний үр дүнд ээжүүдийн нийгмийн асуудал шийдэгдэж чадсан нь сайшаалтай. Н.Номтойбаяр сайд эм үнэгүй олгох тухай журмыг тайлбарлаж хурал хийснээс өөрөөр УИХ-аар ийм чухал хууль батлагдлаа гэсэн хэвлэлийн хурал нэг удаа ч болсонгүй. Харин эсрэгээрээ намайг цахимаар тэгж дарамталлаа, миний зургийг ингэж тавилаа, би хоол идсэн, архи уугаагүй гэсэн явган хэрүүл, явуургүй пиарчдын эсрэг хэвлэлийн хурал хийж суугаа нь худлаа биш. Хуульзүйн сайд нь хүртэл бодлогын чанартай өөрчлөлт шинэчлэлт ярихаасаа өмнө хятад иргэдийг оруулна, оруулахгүй гэсэн "жижигхэн" улс төр хийж явна. Энэ мэт жишээ маш олныг дурьдаж болно. Уг нь УИХ-ын гишүүд жилд нэг удаа хууль сурталчлах нэрээр 10 сая төгрөг авдаг. Одоо ч авсаар байгаа. Энэ мөнгөөр өдөр тутмын

> ...Үгүй ядахдаа л хөдөлмөрийн насны 600 мянган иргэд энэ талаар илүү мэдээлэлтэй байж, татвараа төлж, буцаан олголтоо ч авах учиртай юм. Гэтэл 80 мянга орчим иргэн л их бага хэмжээгээр буцаан олголтоо авчээ. Үлдсэн нэг сая гаруй иргэн ямар ч ойлголтгүйгээс хоосон хоцорлоо. НӨАТ төлөгч аж ахуйн нэгж дөнгөн данган 5000 хүрч байгаа. Цаана нь 135 мянга гаруй аж ахуйн нэгж хуулийг үл тоон, ард түмнийг шулсаар байгаа юм...

сонин хэвлэл, цахим сайт, телевизээр өөрсдийн батлуулсан, өргөн барьсан хуулиа сурталчлах учиртай юм билээ. Хамгийн багадаа л өргөн барихдаа, хэлэлцүүлгийн шатанд, батлсны дараа нийт гурван удаа мэдээлэл хийж, иргэдэд мэдээлэл өгч байж л хуулийн талаар ард түмэн бага ч гэсэн мэдлэгтэй болно. УИХ-аар түүхий хууль баталдаг, хуулиа сурталчлахгүйгээс ямар их хор хохирол учирч байгааг тоочвол цаг ч их орно, цаас ч багадах биз. Монгол төрийн бодлого хуулиа мэддэг иргэнтэй байх бус хууль мэдэхгүйг нь далимдуулж торгож, хорьж, цагдаж, шалгадаг буруу тогтолцоо руу хэдийнэ хальтирчээ. Үнэхээр л иргэнийхээ төлөө хууль баталдаг байсансан бол Долоон буудлын Должин эмээгээс эхлээд хөдөө мал хариулж яваа Дорж, Дулмаад ойлгуулахын тулд хуулиа сурталчлах учиртай бус уу. Өнгөрсөн парламент гэхэдл хууль сурталчлах мөнгөнөөс гурван тэрбум төгрөг танаж төсвийн хэмнэлт хийсэн байгаа юм. Үр дүнд нь ямар ч сурталчилгаагүй хуулиуд хэдэн арваар "мэндэлж", иргэд өнөө хэр хаана ямар хууль батлагдсаныг мэдэхгүй нүдэн балай чихэн дүлий явж байна.

Хамгийн ойрын жишээ дурьдахад л УИХ-аар өнгөрсөн онд баталсан НӨАТ-ын тухай хуулийг төдийлөн сайн сурталчилж чадаагүйн гор нь иргэд НӨАТ-ын буцаан олголтоо авах үед гарав. Хэрвээ энэ хуулийг зөвхөн хэдэн зуун сая төгрөгийн азтан болно гэдгээс илүүтэй сурталчилж чадсан бол 80 мянга биш 800 мянган иргэн НӨАТ-ын буцаан олголтоо авах байжээ. Харамсалтай нь энэ хуулийг тойрсон сайн гэхээс илүү саар мэдээлэл давамгайлж байснаас болж маш олон иргэд буцаан олголтоо авч чадсангүй. Монголд найман настай балчираас 80 настай буурал гээд бүгд худалдан авалт хийж байгаа. Үгүй ядахдаа л хөдөлмөрийн насны 600 мянган иргэд энэ талаар илүү мэдээлэлтэй байж, татвараа төлж, буцаан олголтоо ч авах учиртай юм. Гэтэл 80 мянга орчим иргэн л их бага хэмжээгээр буцаан олголтоо авчээ. Үлдсэн нэг сая гаруй иргэн ямар ч ойлголтгүйгээс хоосон хоцорлоо. НӨАТ төлөгч аж ахуйн нэгж дөнгөн данган 5000 хүрч байгаа. Цаана нь 135 мянга гаруй аж ахуйн нэгж хуулийг үл тоон, ард түмнийг шулсаар байгаа юм. Монголын хууль ингэж л хэрэгжиж байна. Ойлгуулах гэж биш иргэдээ торгож, цагдаж барьж хорих гэж хууль баталдаг учраас маш олон иргэд хуулийн золиос болж, мэдэхгүй, чадахгүй, ойлгохгүйгээс амь нас, эд мөнгө, эд эрхтэнээрээ хохирсоор байгаа юм. Сүр дуулиан болж баталсан хуулийг нь дараагийн парламентын үед хэрэгсэхгүй болгочихдог, эс бөгөөс 180 градус өөрчилж орхидог учраас монголчууд хуульгүй юм шиг амьдарсаар байгаа юм. Өнгөрөгч парламентаар баталсан Тамхины хяналтын тухай хуулийг өдгөө хэн ч дагаж мөрдөхгүй байна.

Монгол төрийн үнэлэмж өдөр бүр унаж байгаа. Улстөрчдийн баталсан хууль, хийсэн ажлыг нь дэмжих гэхээс илүүтэй баасан, шээсэн, уусан идсэнд нь анхаарал хандуулж байгаа юм. Монголын хууль гурав хоног хэмээн үл тоож, хэрэгжүүлэхийг ч тэд хүсэхгүй байгаа. Энэ нь ард түмний буруу биш. Ийм болгосон буруутан нь төр өөрөө. Хуулийг баталсан шиг баталж, сурталчилж, хэрэгжилтэд анхаарал хандуулдаггүй учраас иргэд ч адилхан үл ойшоож, хэрэгжүүлэхийг хүсэхгүй байна. Цаашид энэ хэвээр л явах уу. Монгол төрийн бодлого эзэнгүй юм шиг явсаар байх уу, улстөрчид өө. Хууль сурталчлах, хууль батлуулах ажлаа хийсэн шиг хийгээч. Монголд хэвлэл мэдээллийн байгууллага цөөдөөгүй. Бүгдэнтэй нь биш гэхэд хэсэг бүлэгтэй нь ч болов хамтраад иргэдээ соён гэгээрүүлье. Хуулийн талаар мэдлэгтэй болгоё. Улстөрчдийн боов идсэнд анхаардаг биш бодлого ярьж байгаад нь анхаарал хандуулдаг боловсролтой, мэдлэгтэй иргэдтэй болъё. Монголын хууль гурав хоног гэдэг үгийг ч жинхэнэ утгаар нь хэрэглэж сурахсан. Тэрний тулд улстөрчид, парламент багахан анхаарч төсөвлөсөн мөнгийг нь зохих ёсоор нь хэрэглэмээр байгаа юм. Тэгж чадвал хууль ч чанартай, хэрэгжилтэд нь ч үр дүнтэй болно.


# ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017.02.07
**Тендер шалгаруулалтын нэр:** "Багануур" ХК-ийн 2017-2018 онд хэрэглэх сэлбэг материал нийлүүлэгчийг сонгох
**Тендер шалгаруулалтын дугаар:** СШУ №БНХК-2017-см/01-01/

"Багануур"ХК эрх бүхий тендерт оролцогчдоос Бэлдэц төмөр нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр иж бүрдэл бүхий багцыг 50,000 төгрөгөөр эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн хамт тендерийн нийт үнийн дүнгийн хоёр хувьтай тэнцэх дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны гуравдугаар сарын 9-ний өдрийн 09:00 цагт өмнө хаяг №3–аар ирүүлэх бөгөөд нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны гуравдугаар сарын 9-ний өдрийн 09:30 цагаас нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.**

*Сонирхсон тендерт оролцогч тендерийн баримт бичгийг ажлын өдөр, ажлын цагаар хаяг №1-ээс худалдан авах ба тендертэй холбогдолтой мэдээллийг хаяг №2-оос авч болно.*

**Хаяг №1:** Улаанбаатар хот. Баянзүрх дүүрэг. "Багануур" ХК-ийн төлөөлөгчийн байр. Төлөөлөгч Р.Энхбаатар Утас : 70157719 99098715, Факс : 70157719
**Хаяг №2:** Техникийн Бодлогын Хэлтсийн дарга Х.Хашбат Утас:70210351, Факс : 70210364
**Хаяг №3:** Багануур дүүрэг. "Багануур" ХК-ийн захиргааны байр. 304-н тоот
Худалдаа хангамж хариуцсан хэлтсийн менежер Ч.Чулуунбат Утас: 70210927

**БАГАНУУР ХУВЬЦААТ КОМПАНИ**

# ДЭЛХИЙ



...Мелани өмнөх тэргүүн хатагтай Мишель Обама, Жаклин Кеннеди нарыг магтаж, нийгмийн сүлжээ дэх ялгаварлан гадуурхалтыг шийдвэрлэх боломжийн талаар ярьснаас өөрөөр өөрийг нь илэрхийлэх тэргүүн хатагтайн үзэл бодлын талаар нэг ч зүйл хэлсэнгүй...

## МЕЛАНИ ТЭРГҮҮН ХАТАГТАЙН УЛАМЖЛАЛЫГ ЭВДЭХ ҮҮ

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Гэвч, шинэхэн тэргүүн хатагтай түүнээс хойш албан ёсны ямар ч үйл ажиллагаанд оролцож харагдсангүй. Бүр Цагаан ордонд ч амьдраагүйгээр барахгүй түүнтэй хамтарч ажиллах багийнхны сонгон шалгаруулалт нь ч дуусаагүй гэнэ. Тангараг өргөх ёслолоос хойш Мелани нийслэл Вашингтон ДС хотын сүмд болсон үйл ажиллагаанд л оролцсоноос хэтэрсэнгүй. Ердөө хэдхэн удаа л тэд хамтдаа олны нүдэнд өртсөн хэрэг.

Улмаар нөхөр нь Ерөнхийлөгчийн албаа албан ёсоор хүлээж авснаас хойш төд удалгүй Цагаан ордныг орхиж, Нью Йорк дахь гэртээ нисдэг тэрэг, онгоц, хувийн хэрэглээний машин хослуулж, нийтдээ 90 минут зарцуулан байж хүрсэн гэдэг. Ойрын өдрүүдэд ч шинэхэн хатагтай Цагаан ордонд очих төлөвлөгөөгүй тухай орон нутгийн эх сурвалжууд мэдээлж байна. Мелани өмнө нь 10 настай Баррон Трампын сургуулийн улирлын амралт хүртэл Нью-Йорк амьдарна гэдгээ илэрхийлж байсан удаатай. Гэхдээ л эдүгээг хүртэл АНУ-д хэвшсэн тэргүүн хатагтайн талаархи ойлголтыг тэрбээр үндсэндээ өөрчилж орхилоо. Өнгөрсөн сарын 31-нд Д.Трамп Пентагоны тэргүүнийг томилох үед Мелани байсангүй. Энэ сарын 1-нд Охио мужийн Делавер руу явж, дайнд амь үрэгдсэн америк цэргүүдийн дурсгалыг хүндэтгэж, ар гэрийнхэнд нь эмгэнэл илэрхийлэх ёслолын үеэр ч Мелани бас л харагдсангүй. Харин тэргүүн хатагтайн оронд Иванка Трамп эцгээ дагалдан явсан нь тухайн үед олныг гайхшруулаад амжсан байдаг.

Ер нь АНУ-ын түүхэн дэх үе үеийн тэргүүн хатагтай нарыг аваад үзэхэд үнэндээ Мелани шиг Цагаан ордонд нүүж очоогүй тохиолдол бараг байсангүй. Тийм ч учраас хэвлэлүүд Мелани үнэхээр тэргүүн хатагтайн үүрэг гүйцэтгэж чадах эсэхэд ч эргэлзэж эхэлжээ. Тэргүүн хатагтай гэж хэнийг хэлэх вэ. Энэ асуултад үе үеийн тэргүүн хатагтай нарын талаархи олны дунд хэвшсэн ойлголтыг судлаад үзье. "Коннектикут" коллежийн улс төр судлаач МэриАнн Борелли "Тэргүүн хатагтай ихэвчлэн өөрийн бодлого чиглэлээ гурав эсвэл дөрөвдүгээр сард танилцуулдаг. Ерөнхийлөгч тангаргаа өргөснөөс хойш 100 хоногт үндсэндээ бататгадаг" гэж ярьжээ. Гэтэл Мелани өмнөх тэргүүн хатагтай Мишель Обама, Жаклин Кеннеди нарыг магтаж, нийгмийн сүлжээ дэх ялгаварлан гадуурхалтыг шийдвэрлэх боломжийн талаар ярьснаас өөрөөр өөрийг нь илэрхийлэх тэргүүн хатагтайн үзэл бодлын талаар нэг ч зүйл хэлсэнгүй. Бүр тангараг өргөх ёслолоос хойш тэрбээр фэйсбүүк, твиттер хуудастаа ердөө л ганц удаа буюу нэгдүгээр сарын 21-нд тэргүүн хатагтайн үүрэг гүйцэтгэх болсноо "Нэр төрийн хэрэг" хэмээн жиргэсэн байсан юм.

Түүнээс өөрөөр юу ч нийтэлсэнгүй. Америкчууд шинэ тэргүүн хатагтайгаа тийм ч өндрөөр үнэлдэггүй. Учир нь Мелани Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр тавьсан илтгэлдээ Мишель Обамагийн үгнээс хулгайлж, олны доог тохуу болж, Д.Трампын дэмжигчдийн хувь буурахад зохих хувь нэмрээ оруулсан байдаг. Тиймээс алдагдсан нэр хүндээ эргүүлэн олохын тулд тэрбээр яаж ч бодсон энэ өдрүүдэд нөхрийнхөө дэргэд байж, олны хараанд өртөх ёстой байсан гэж дүгнэж болохоор. Гэхдээ тэргүүн хатагтай бүр нэр хүндтэй байсан гэж үзвэл эндүүрэл болно. Учир нь Мишель Обама АНУ-ын анхны Африк гаралтай тэргүүн хатагтай байсан. Үүнийх нь төлөө түүнийг олон нийт Хиллари Клинтон, Элеонора Рузвельт нартай харьцуулж харж байсан учир "дуулгавартай гэрийн эзэгтэй" гэх хэв маягийг өөрчлөхийн тулд эхэндээ хүнд бэрх шүүмжлэлийг тэсч гарсан удаатай. Харин Мелани энэ хэвээр олны харцнаас дөлж амьдарсаар байвал үе үеийн тэргүүн хатагтай нарын талаар хэвшмэл ойлголтыг эвдэхээс эхлээд төрийн тогтсон уламжлалыг хүртэл "Шинэчлэгч" болж ч мэдэхээр байна.

## "Лалын улс" бүлэглэлтэй холбоо бүхий 700 гаруй хүн саатуулагдав

Туркийн цагдаа нар тус улсын 29 мужид "Лалын улс" бүлэглэлтэй холбоотой байж болзошгүй сэжигтэй хүмүүсийг баривчлах ажиллагаа явууллаа. Аюулгүй байдлын ерөнхий газрын мэдээлснээр, баривчлагдсан хүмүүсийн тоо 763 болсон байна. Тусгай ажиллагааг энэ сарын 5-нд нэгэн зэрэг 29 мужид явуулж эхэлжээ. Мужуудын аюулаас хамгаалах байгууллагуудын терроризмтой тэмцэх албаны ажилтнууд "Лалын улс"-ын гишүүд оршин сууж байх магадлалтай газруудад нэгэн зэрэг самналт нэгжлэг хийсэн байна. Саатуулагдсан хүмүүсийн гэр орноос нь хэвлэсэн болон цахим хэлбэрээр үйлдсэн "Лалын улс"-тай холбоотой бичиг баримтууд, исламын болон хэт даврах үзлийг сурталчилсан номууд их хэмжээгээр олдсон төдийгүй бүртгэлгүй хоёр гар буу, дөрвөн урт буу, 370 гаруй сум илрүүлэн хураажээ. Ням гарагт явуулсан самналт нэгжлэгийн явцад 400 орчим сэжигтнийг саатуулсан байна. Тэднээс хамгийн олон хүнийг Шанлыурфа /150/, Анкара /60/, Газиантеп /47/, Бурса /46/ зэрэг мужуудад баривчилжээ. Цагдаагийн нэгжлэг самналт Стамбул, Измир болон Туркийн нутгуудад ч хийгджээ. Сэжигтнүүдийн дунд алан хядагчдын үйл ажиллагаагаа явуулж буй бүс нутгууд болон Сири рүү тогтмол зорчдог байсан гадаадын иргэд ч байгаа аж.

## Румынчууд Засгийн газраа огцруулахаар жагслаа

Зүүн Европт орших Румын улсын иргэд авлигачдад өршөөл үзүүлэх шийдвэр гаргасан Засгийн газраа эсэргүүцэн зургаа дахь удаагаа жагслаа. Энэ удаагийн эсэргүүцлийн жагсаалд 500 гаруй мянган хүн оролцжээ. Жагсагчдын тоо улам нэмэгдэж буйтай холбогдуулан Сорин Гриндянугийн Засгийн газар хорих ангиудын ачааллыг бууруулах шийдвэрээ эргүүлэн татсан ч, хотын иргэдийн ширүүн тэмцлээс бултах боломжгүй болжээ. Ойрын үед түүний Засгийн газрын эсэргүүцсэн жагсаал цуглан улам бүр хүчээ авсаар байна. Румыны хот бүрт өрнөж буй эсэргүүцлийн жагсаал 1989 онд Николае Чаушескугийн засаглалыг түлхэн унасанаас хойшхи хамгийн өргөн хүрээтэй жагсаал болж буйгаараа онцлог юм.

Энэ сарын 5-нд болсон эсэргүүцлийн жагсаалд оролцогчид "Огцор, огцор" хэмээн хашгирч, төрийн далбаа, элдэв лоозон барин бүрээ, шүгэл үлээн эсэргүүцлээ илэрхийлж байжээ. Гэвч Засгийн газраа байгуулаад ердөө сар гаруйхан хугацаа үдээд буй Ерөнхий сайд Гриндяну "Бидэнд саналаа өгсөн иргэдийн өмнөх хүлээх хариуцлага бий" хэмээж огцрохоос татгалзсаар байгаа сурагтай. Румыны Засгийн газраас Эрүүгийн хууль чанга байгаагаас үүдэн шоронгууд хэт олон хоригдолтой болж, хорих газрын зардал төсөв хүндэрсэн шалтгаанаар зарим хөнгөн ялтай хэрэгтнүүдийг суллах шийдвэр гаргасан байдаг. Гэвч хөнгөн ялтай гэмт этгээдүүд гэдэг ангилалд авлига авсан, албан тушаалаа урвуулан ашигласан хүмүүс ч цөөнгүй байгаа нь ард иргэдийн дургүйцлийг төрүүлжээ. Улмаар авлигачдын суллах зорилгоор зориуд ийм шийдвэр гаргасан гэх хардлага нийгэмд хүчээ авч эхэлсэн байна.

## Цасан нуранги дарагдаж, 100 гаруй хүн амиа алджээ

Афганистаны ихэнхи нутгаар их хэмжээний цас унажээ. Үүний улмаас хэд хэдэн удаа цасан нуранги үүсч, гурван өдрийн дотор 100 гаруй хүн амиа алдсан байна. Нэг тосгонд бүр 50 хүн нэг дор амиа алдсан харамсалтай явдал болсон байна. Цаашид хохирогчдын тоо нэмэгдэж магадгүй байгаа аж. Хамгийн их хохирол амссан нь Афганистаны зүүн этгээдийн Нуристан муж гэнэ. Албаны эх сурвалжийн мэдээлснээр "Баргматал дахь хоёр тосгон тэрчигтээ цасанд дарагдсан байх бөгөөд нэг тосгоноос нь л гэхэд 50 хүний цогцсыг гаргасан байна. Харин нөгөө тосгонд нь аврах албаныхан дөнгөж хүрч байгаа гэнэ. Мөн хойд болон төв хэсгийн мужуудад 54 хүн мөн энэ шалтгааны улмаас амиа алдсан байх юм. Их цасанд нийтдээ 168 айлын байшин дарагдаж, тэжээвэр амьтад ч үхэж, үрэгджээ.

Бадахшан мужид шөнө дундын үед цасан нуранги олон тооны айлын байшинг дарсны улмаас дотор нь байсан гурван эмэгтэй хоёр хүүхэд гээд нийтдээ 18 хүн амиа алджээ. Харин Сари Пул гэх мужийн Балхаб хотод ч гурван хүн цасан нурангид дарагдаж амьсгал хураасан байсан. Тухайн үед 70 хүн цасанд дарагдсан ч, аврах ажиллагааг шуурхай явуулсны дунд 67 –ынх нь амийг аварч чаджээ. Үүнээс гадна Кабул хотын хойд хэсэгт байрлах Парван мужид 16 хүн хохирсон гэнэ. Яаралтай нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан Афганистаны Засгийн газраас даваа гарагийг амралтын өдөр болгосноос гадна шаардлагагүй тохиолдолд гадагш гарахгүй байх, сургууль цэцэрлэгийг түр хугацаанд ажиллахгүй байхыг үүрэгджээ.


## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017.02.07
**Тендер шалгаруулалтын нэр:** "Багануур" ХК-ний 2017-2018 онд хэрэглэх сэлбэг материал нийлүүлэгчийг сонгох
**Тендер шалгаруулалтын дугаар:** СШУ ºБНХК-2017-СМ/01-02/

"Багануур" эрх бүхий тендерт оролцогчдоос Экскаватор ЭКГ-5А, 4У, 8И, 10И, ЭШ15/90, 20/90 шүднүүд нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр иж бүрдэл бүрийг нь 50000 төгрөгөөр эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн хамт тендерийн нийт үнийн дүнгийн хоёр хувьтай тэнцэх дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны гуравдугаар сарын 9-ний өдрийн 09:30 цагаас өмнө доорх гурван хаягаар ирүүлэх бөгөөд нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны гуравдугаар сарын 09 -ний өдрийн 10:00 цагт Багануур ХК-ий захиргааны байранд нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.**

*Сонирхсон тендерт оролцогч тендерийн баримт бичгийг ажлын өдөр ажлын цагаар хаяг №1-ээс худалдан авах, тендертэй холбогдолтой мэдээллийг хаяг №2-оос авч болно.*

**Хаяг №1:** Улаанбаатар хот. Баянзүрх дүүрэг. "Багануур" ХК-ний төлөөлөгчийн байр. Төлөөлөгч Р.Энхбаатар
Утас : 70157719,99098715,99023137, Факс : 70157719
**Хаяг №2:** Техникийн бодлогын хэлтсийн дарга Х.Хашбат
Утас : 70210351 Худалдаа хангамжийн менежер Ч.Чулуунбат
Утас: 70210927, Факс : 70210364
**Хаяг №3:** Багануур дүүрэг. "Багануур" ХК-ийн захиргааны байр.
304-н тоот Худалдаа хангамжийн менежер Ч.Чулуунбат
Утас: 70210927

**БАГАНУУР ХУВЬЦААТ КОМПАНИ**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017.02.07
**Тендер шалгаруулалтын нэр:** "Багануур" ХК-ний 2017-2018 онд хэрэглэх сэлбэг материал нийлүүлэгчийг сонгох
**Тендер шалгаруулалтын дугаар:** СШУ ºБНХК-2017-СМ/01-03/

"Багануур" эрх бүхий тендерт оролцогчдоос Канат тросс нийлүүлэх /11-64/ тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр иж бүрдэл бүрийг нь 50000 төгрөгөөр эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн хамт тендерийн нийт үнийн дүнгийн хоёр хувьтай тэнцэх дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны гуравдугаар сарын 10-ны өдрийн 09:00 цагаас өмнө доорх гурван хаягаар ирүүлэх бөгөөд нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны гуравдугаар сарын 10-ны өдрийн 09:30 цагт Багануур ХК-ий захиргааны байранд нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.**

*Сонирхсон тендерт оролцогч тендерийн баримт бичгийг ажлын өдөр ажлын цагаар хаяг №1-ээс худалдан авах, тендертэй холбогдолтой мэдээллийг хаяг №2-оос авч болно.*

**Хаяг №1:** Улаанбаатар хот. Баянзүрх дүүрэг. "Багануур" ХК-ний төлөөлөгчийн байр. Төлөөлөгч Р.Энхбаатар
Утас : 70157719,99098715,99023137, Факс : 70157719
**Хаяг №2:** Техникийн бодлогын хэлтсийн дарга Х.Хашбат
Утас : 70210351 Худалдаа хангамжийн менежер Ч.Чулуунбат
Утас: 70210927, Факс : 70210364
**Хаяг №3:** Багануур дүүрэг. "Багануур" ХК-ийн захиргааны байр.
304-н тоот Худалдаа хангамжийн менежер Ч.Чулуунбат
Утас: 70210927

**БАГАНУУР ХУВЬЦААТ КОМПАНИ**

# ДАВАРСАН ИМПОРТЛОГЧДЫГ ДАРАХ ЦАГ НЬ БОЛСОН БАЙЛТАЙ

## Эсрэг тэсрэг байр суурь



### Ц.Дашдорж: Автобензинийн үнэ нэмэгдэхгүй

*/Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд/*

-Засгийн газраас автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын хэмжээг бууруулахаар боллоо. Өөрөөр хэлбэл, бензиний онцгой албан татварыг тонн тутамд 100 мянган төгрөгөөр бууруулллаа. Энэ нь шатахууны жижиглэнгийн үнийг хөдөлгөхгүй, Засгийн газар өөрийнхөө эрх мэдлийн хүрээнд уг асуудлыг зохицуулж байна. Шатахууны жижиглэнгийн үнийн асуудал ард иргэдийн нуруун дээр очдог. Тиймээс ч энэ дарамтыг багасгах асуудалд онцгой анхаарлаа хандуулж байгаа юм. Ийнхүү татварын хөнгөлөлт эдлүүлэх болсоны учир нь зарим газарт шатахууны жижиглэнгийн үнэ өссөн байгаа. Тиймээс ч ийм арга хэмжээ авч байна. Энэ хүрээнд шатахуун импорлтогч компаниуд Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Засгийн газар буюу Сангийн яаманд өөрийн зохих ёсны удирдамжаа хүргүүлсэн байгаа.

...Шатахууны жижиглэнгийн үнийн асуудал ард иргэдийн нуруун дээр очдог. Тиймээс ч энэ дарамтыг багасгах асуудалд онцгой анхаарлаа хандуулж байгаа юм. Ийнхүү татварын хөнгөлөлт эдлүүлэх болсоны учир нь зарим газарт шатахууны жижиглэнгийн үнэ өссөн байгаа...

...Манайх бүх салбарынхаа үнийг нэмээгүй. 2-3 хан станцын үнэ нэмэгдсэн байгаа. Төрөл тус бүртээ өөр, өөр үнийн дүнгээр нэмэгдсэн. Зарим нь 75 төгрөгөөр нэмэгдсэн байгаа. Яагаад нэмэгдсэн талаар тайлбар өгөх боломжгүй...




### Шунхлай: Манайх бүх салбарынхаа үнийг нэмээгүй

*/"Шунхлай" компанийн зүгээс/*

-Манайх бүх салбарынхаа үнийг нэмээгүй. 2-3 хан станцын үнэ нэмэгдсэн байгаа. Төрөл тус бүртээ өөр, өөр үнийн дүнгээр нэмэгдсэн. Зарим нь 75 төгрөгөөр нэмэгдсэн байгаа. Яагаад нэмэгдсэн талаар тайлбар өгөх боломжгүй.



### Ч.Чулуунбат: Шатахууны үнийн өсөлтийг саармагжуулах арга хэмжээ авлаа

*/УХҮЯ-ны Түлшний бодлогын газрын дарга/*

-Газрын тос олборлогч орнууд арваннэгдүгээр сарын 30-нд хуралдаж, олборолтынхоо тоо хэмжээг буулгаснаас хамаараад, сүүлийн сар гаруйн хугацаанд газрын тосны үнэ 20 гаруй хувиар өсөөд байна. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсад нийлүүлж байгаа газрын тосны бүтээгдэхүүний үнэ өсч орж ирж байгаа. Өмнө нь бас валютын ханшийн чангаралтаас хамаараад мөн цаг тухай бүрт нь өнгөрсөн оны аравдугаар сарын 05 болон арваннэгдүгээр сарын 30-нд Засгийн газрын хуралдаанаар онцгой албан татварын хувь хэмжээгээр зохицуулалт хийж байсан. Өөрөөр хэлбэл, дотоодод борлуулж байгаа шатахууны жижиглэнгийн үнийг тогтвортой байхаар арга хэмжээг авч ирсэн. Энэ удаад ч газрын тосны үнийн өсөлт дотоодод борлуулах жижиглэн борлуулалтын үнийн хэмжээнд нөлөөлөх хэмжээнд очсон учир Засгийн газраас онцгой албан татварын хувь хэмжээг 110-130 мянган төгрөгөөр буулгаж, үнийн өсөлтийг саармагжуулах арга хэмжээг авлаа. Өнөөдрийн байдлаар /2016.01.25/ Монгол Улсад газрын тосны хэвийн хэрэглээний 48 хоногийн нөөц байна. Ер нь бол шатахуун импортлогч компаниуд 30-аас доошгүй хоногийн нөөцтэй байх үүрэгтэй байдаг.

## Сэтгүүлчийн дүгнэлт

### ТӨРИЙН ХАЙР ЭНЭРЭЛД "ТАЛАРХСАН" КОМПАНИУДЫН ХАРИУ ЭНЭ...

Ж.ОТГОН

Засгийн газрын өнгөрөгч нэгдүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар автобензин, дизель түлшний үнийн өсөлтийг саармагжуулах, тогтвортой барих зорилгоор энэ төрлийн бүтээгдэхүүнд ногдуулах Онцгой албан татварын хэмжээг бууруулсан. Ингэхдээ автобензинд ногдуулах онцгой албан татварыг 160 мянган төгрөгөөс 50 мянга болгож, /90-ээс дээш октантайг 160 мянгаас 30 мянга/, дизель түлшинд ногдох татварыг 180 мянгаас 70 мянган төгрөг болгон бууруулж тогтоосон. Энэ нь улсын төсвийн орлогыг 110 орчим тэрбум төгрөгөөр бууруулах ч, шатахууны үнийн өсөлтийг саармагжуулах боломжтой гэж холбогдох яам болон Газрын тосны бүтээгдэхүүн импортлогчдын холбоо үзэж байсан.

Гэвч энэхүү төрийн хайр энэрэлд "талархсан" компаниудөнгөрсөнамралтынөдрүүдэдшатахууны үнээ нэмж орхив. Гэхдээ бүгд бас нэмчихээгүй байна аа. Тоочоод нэрлэбэл, томчууд нь буюу "Петровис", "Шунхлай" гэх хоёр том компани шатахууны үнээ энэ сарын 05-ны өглөөнөөс эхлээд литр тутамдаа 90-100 төгрөгөөр нэмсэн байх юм. Тухайлбал, "Петровис" АИ-92 төрлийн шатахууныг 1630 төгрөгөөр борлуулж байгаа бол "Шунхлай"-д 1625 болон өссөн байна. Шатахууны үнийг дагаад бүх бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгддэг манай улсын хувьд шатахууны үнийн өсөлт ард иргэдэд маш хүнд дарамт болдог. Ялангуяа өнөө маргаашгүй төрт ёсны хамгийн том баяр цагаан сар болох гэж байхад шатахуун импорлогч компаниудын энэ "бэлэг" монголчуудад үнэхээр хүнд тусч байна.

Энэ мэт асуудал үүсдэг учир л Засгийн газраас тухай бүрт нь зохицуулалт хийдэг байлтай. Гэвч нефть импортлогчид үнээ ямар нэгэн санаа зовох зүйлгүйгээр нэг л өглөө нэмчих юм. Үнээ нэмсэн шалтгааныг дэлхийн зах зээл баррель нефтийн үнэ 20 хувиар өссөн нь Монголд үнэ нэмэгдэх шалтгаан болсон гэж тайлбарлаж байгаа. Гэвч энэ байдлаас нь л урьдчилан сэргийлж төсвийн орлогыг 110 орчим тэрбум төгрөгөөр бууруулан байж Засгийн газраас дээрх шийдвэрийг гаргасан шүү дээ.

Удаа дараа хөнгөлөлт эдэлж, овойж оцойтол ашиг олж байгаа "Петровис"-ын Ж.Оюунгэрэл, "Шунхлай"-н Г.Батхүү нар ханаж цадахаа мэдэхгүй байгаа бололтой. Мэдээллийн эрин үед амьдарч байгаа монголчууд дэлхийн зах зээл дээр ч хамгийн сайн чанарын нефть нэг баррель нь 53 ам.доллараар зарагдаж байгааг мэдэж байгаа. Тэгэхээр манайд орж ирж байгаа бензин тийм ч сайн чанарынх гэдэгт итгэхгүй байна. Тэгвэл машинтай нөхөд минь өнөөдрөөс "Петровис", "Шунхлай" хоёроос бензин битгий аваарай. Ингээд л шийтгэл болно. Даварсан нөхөд алдагдал хүлээх нь дамжиггүй. Засгийн газрын шийдвэрийг сөрдөг, даам гарчихсан дээрх "ариун явдалтангуудад" хариуцлага тооцох цаг болсон юм биш үү. Ерөнхий сайд аа. МАН-ынхан ямар өртэй болохоороо Ж.Оюунгэрэлийн толгойг илж, овойж оцойтол баяжихыг нь хүлээн зөвшөөрөөд байдаг юм бэ. Засгийн газрын тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах үүрэг хүлээсэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Б.Лхагва нар ажлаа хийгээч.




### Петровис: Шатахууны үнийг 100 төгрөгөөр нэмсэн

*/"Петровис" компанийн маркетингийн мэргэжилтэн/*

-Бүх салбарынхаа шатахууны үнийг 100 төгрөгөөр нэмсэн. Ганцхан манайх үнэ ханшдаа өөрчлөлт оруулаагүй, шатахуун импортлогчид ярилцаж байж, литр тутмынхаа үнийг нэмсэн.

## ЦАГ ҮЕ

ЗАСАГ ДАРГА ЯРЬЖ БАЙНА

Б.ОДНОО

*Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргилтой цаг үеийн асуудлаар ярилцлаа.*



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# Ш.Оргил: ХИЙЕ, БҮТЭЭЕ ГЭСЭН ХЭНИЙГ Ч

**-Сэлэнгэ аймгийн Засаг даргаар томилогдсоноос хойш харьцангуй бага хугацаа өнгөрсөн хэдий ч, хэд хэдэн бүтээлч ажлыг өрнүүлж чадсан. Сүүлийн үед ямар ажлыг амжуулав. Энэ асуултаас ярилцлагаа эхлэе?**

-Ажилдаа томилогдоод таван сар шахам хугацаа өнгөрсөн байна. Энэ хугацаанд аймгийн гадаад харилцааг эдийн засагжуулах, үр нөлөөг дээшлүүлэх замаар уламжлалт харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэн, шинэ түншлэлийг нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлж, хэд хэдэн гэрээ хэлэлцээр, төсөл хөтөлбөрүүдийг баталгаажуулан хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээд байна. Тухайлбал, Монгол Улсад суугаа Энэтхэг улсын Элчин сайд, Кувейт улсын Элчин сайд, АНУ-ын Элчин сайдын яамны Ерөнхий консулын албан ёсны айлчлалыг аймагтаа зохион байгуулж, АНУ-аас хамтын ажиллагааны чиглэлээ тодорхойлох, Энэтхэг улсаас хөдөө аж ахуйн салбарт мэргэжилтэн бэлтгэх, Кувейт улсаас Сүхбаатар, Мандал сумдын Нэгдсэн эмнэлэгт иж бүрэн тоноглогдсон түргэний машин, тоног төхөөрөмж хандивлах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр боллоо. Монгол Улсын Ерөнхий сайдын Япон улсад хийсэн албан ёсны айлчлалын бүрэлдэхүүнд миний бие орж ажиллан тус улсын Шизуока мужтай газар тариалангийн салбарт хамтран ажиллахаар “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг байгууллаа. Турк улсын хамтын ажиллагаа зохицуулах агентлаг \ТИКА\-тай хамтран ажиллах гэрээг байгуулж, Шаамар суманд “Зөгийн зоорь барих”, аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт “Эрчимт эмчилгээний тасаг байгуулах” хэлэлцээрүүдийг баталгаажууллаа. ОХУ-ын Буриад Улс, БНХАУ-ын ӨМОЗО, БНСУ-д эрүүл мэнд, боловсролын салбарын мэргэжилтнүүдийг туршлага судлах арга хэмжээнд хамруулж, ХБНГУ-ын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн ЭТИС хөтөлбөрийн хүрээнд цаашид хамтарч ажиллах салбар чиглэлээ тодорхойлсон. Ирэх онд гадаад харилцааны чиглэлээр Оросын Холбооны Саха (Якутия) Улс, Турк Улсын Кыршехир муж, БНСУ-ын Жон сон, Гангвон мужуудтай шинэ харилцаа тогтоохоор албан хүсэлтээ уламжлаад байна. Хамтын ажиллагааны хүрээнд хоёр талын найрсаг харилцаа өргөжихийн зэрэгцээ бусад улс орон, муж хотуудын хөгжлийн давуу талуудын сайн туршлага, санал санаачлагыг аймаг орон нутагтаа хэрэгжүүлж, хүүхэд залуучуудыг сургах боломжийг бүрдүүлэн аймгийн гадаад харилцааны үр өгөөжийг нэмэгдүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна.

**-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрөө боловсруулж батлууллаа. Хөтөлбөрийн онцлог болоод ирэх жилүүдэд баримталж ажиллах зарчмаасаа онцлохгүй юу?**

-Аймгийн Засаг даргын ажлыг аваад юуны түрүүнд ирэх жилүүдэд Сэлэнгэ аймгийн хаана, аль сум, тосгон, багт тулгамдсан чухал ажлууд юу байна, тэр ажлуудыг хэрэгжүүлэх ямар боломж, шийдэл байна гэдэгт анхаарсан. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргатай ярилцаж хуваарь гарган сумдад ажиллаж, ард иргэдийн санаа бодлыг нь сонссон. Мөн аймгийн цахим хаяг, 7036-1111 утсаар болон сум, аймгийн ИТХ-д сонгогдсон Төлөөлөгчдийн санал, хүсэлтийг авч судлан үйл ажиллагааны хөтөлбөртөө бололцооныхоо хэрээр тусгахыг хичээлээ. Энэ удаагийн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд зөвхөн төрийн байгууллага, аймаг, сумын Засаг дарга нар үүрэг хүлээх биш, иргэдийн хүч оролцоо, хамтын зүтгэл чухал. Энэ ч утгаараа хөтөлбөрийнхөө эрхэм зорилгыг “ХАМТЫН ЗҮТГЭЛЭЭР ЭХ НУТГАА ХӨГЖҮҮЛЬЕ” гэж тодорхойлсон байгаа. Эдийн засаг, нийгмийн, төрийн захиргааны гэсэн гурван хөгжлийн салбараа тэр нь энэ нь гэх юм байхгүй анхаарч ажиллах нь аймгийн Засаг даргын үүрэг. Үнэхээр онцлоочгэвэл нийгмийн буюу боловсрол, эрүүл мэнд, спорт, нийгмийн халамжийн салбарыг хэлэх байна. Эрдэм боловсролтой, эрүүл чийрэг иргэдтэй байж Сэлэнгэ аймаг цаашлаад улс хөгжинө гэж боддог. Жишээ нь эмнэлэгт жаргалтай хүмүүс очихгүй, өвдөж шаналсан хүмүүс үйлчлүүлнэ. Тиймээс аймгийн зүгээс энэ салбартаа онцгой ач холбогдол өгөх нь зүйтэй гэж боддог.

**-2016 он Сэлэнгийнхэнд хишиг буянаа харамгүй хайрласан сайхан жил байлаа. Тариаланчид маань ургац арвинтай, хүчит бөхчүүд нь шинэ цолтонгуудтай байлаа шүү дээ?**

-2016 он сэлэнгэчүүдэд сайхан жил болж өнгөрч байна. Аймгийн маань хоёр сайхан залуу Улсын цолтны эгнээнд багтлаа. Эх орныхоо талх, тарианы хэрэгцээний 60-аас илүү хувийг үйлдвэрлэдэг тариаланчид маань ургац арвин байж аймгийн дундаж 17.0 цн үр тариа хураан авлаа. Долоо дахь удаагийн олон түмэн төрдөө төлөөллөө сонгох сонгууль болж Сэлэнгэчүүд МАН-д итгэл хүлээлгэлээ. Аж ахуй нэгжүүд аж үйлдвэрийн салбарт 276.2 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. 2016 он хэдийгээр сонгуулийн жил байсан ч Сүхбаатар суманд ард иргэд, хүүхэд залуучуудынхаа амралт чөлөөт цагийг зохистой өнгөрүүлэх “Усан бассейн”-ы цогцолбор, гэр бүлээ батлуулж буй иргэд, ахмадуудаа зориулж “Хуримын ордон”-ыг ашиглалтад оруулаа. Мөн Сэлэнгэ аймгийн ард түмэндээ зориулж “Сэлэнгэ Олон Улсын Худалдааны төв”, “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийг нээн үйл ажиллагааг нь жигдрүүлж, нийт 300 гаруй иргэн тохилог ажлын байртай боллоо. Үүний зэрэгцээ Орхон, Сант, Ерөө Хүдэр сумын ард иргэдийн олон жилийн хүлээлт болсон хатуу хучилттай авто замыг тавьж, Сант суманд 320, Мандал суманд 640 хүүхдийн сургууль, Шаамар суманд 100, Бугант тосгонд 100, Хэрх тосгонд 75 ортой хүүхдийн цэцэрлэг, Сүхбаатар сумын IV цэцэрлэгт 100, 7-р цэцэрлэгт 75 ортой өргөтгөлийн барилгыг барьж ашиглалтад оруулаад байна. Ерөө сум, Түнхэл тосгонд гүүр барьж, Баруунбүрэн суманд “Бүрэнхан” цогцолборыг, аймгийн хилийн цэс Тахилтын давааг тохижуулан, Алтанбулагийн хилээр дайран өнгөрч буй дотоод, гадаадын жуулчид, иргэдэд зориулж нийтийн бие засах газрыг бий болгож, Сант, Орхон суманд наадмын талбайг шинээр байгууллаа.

> ...Манайх чинь есөн удаа улсынхаа шилдгээр шалгарч байгаа бахархам амжилттай аймаг. Дээрээс нь төрийн гурван одонтой анхны аймаг. Энэ амжилтуудыг гаргахад айл бүр нь ажилсаг, өрх бүр нь үйлдвэрлэгч ард иргэдийн маань оролцоо чухал байсан нь тодорхой. Энэ ч утгаараа би 2016-2020 оны үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Хамтын зүтгэлээр эх нутгаа хөгжүүлье” гэж тодорхойлсон юм. Хүн бүр л өмнөө тавьсан зорилтоо, хариуцсан ажлаа ямар нэгэн асуудалгүй, сэтгэлээсээ хийгээд байвал амжилтад хүрнэ гэж би боддог...

**-Сэлэнгээс Монгол төрийн 29 дэх Ерөнхий сайд тодорсон явдал 2016 оны онцлох үйл явдал мөн байх?**

-Тийм ээ. Сэлэнгэ нутгийн уугуул, өмнө нь аймгаа удирдаж байсан Ж.Эрдэнэбат гишүүн Монгол төрийн өндөр албан тушаалд томилогдлоо. Ардын хувьсгалын түүчээ болж явсан өвөг дээдсийн үргэлжлэл Ардчилсан нийгэмд улсынхаа хөгжлийг удирдан чиглүүлэх үйл хэрэгт манлайлан яваа нь бид бүхний л бахархал юм даа.

**-Та нэг талаар азтай, нөгөө талаасаа өндөр хариуцлагатай алба хашиж байна уу даа. Учир нь аливаа том асуудлуудаа шийдэхэд Ерөнхий сайдын дэм чухал, эсрэгээрээ сайн ажиллахгүй бол Ерөнхий сайдтай нутаг байж гээд асуудлууд гарах байх даа?**

-Би Ж.Эрдэнэбат Ерөнхий сайдыг өмнө нь аймгаа удирдаж байхад багт нь ажиллаж байлаа, одоо улсаа удирдаж байхад нь бас багт нь ажиллаж байна. Даргынхаа ажиллаж байсан өрөөнд нь залгамжлаад аймгийнхаа төлөө, сэлэнгэчүүдийнхээ хөгжлийн төлөө ажиллаж байгаа нь бахархал хэдий ч нөгөө талаасаа надад их хариуцлага хамт яваag байнга бодож явдаг. Төрийн ажилд ар, өврийн асуудал гэж байхгүй. Өнөөдөр гэхэд л Монгол орны хэмжээнд цас ихтэй өвөл болж байна. Цагаан зудтай хэдэн аймгийн тоонд Сэлэнгэ аймаг багтсан. Ерөнхий сайдын аймаг гээд цас тойроогүй л байгаа биз дээ. Тэгэхээр бид хаа хаанаа хариуцлагатай ажиллах нь чухал. Зарим асуудлууд дээр мэдээж Ерөнхий сайдын дэмжлэг, тэр хүний Сэлэнгээ гэх сэтгэлийг дааж ажиллана гэж бодож байгаа. Чухал асуудлуудаа шийдвэрлүүлж авах нь Сэлэнгэ аймгийн 105.0 мянган ард иргэдэд л хэрэгтэй.

**-Сэлэнгэ аймгийн хөгжлийн ирээдүйг хэрхэн төсөөлж байна вэ?**

-Наад асуултад чинь хариулахаас өмнө бидний өнөөдрийн тэргүүлэх бодлого зорилт, тулгамдаж байгаа ямар асуудлууд байна вэ гэдгээ оновчтой тодорхойлж, зарим асуудлуудыг маргааш гэж хойш тавилгүй хийж эхлэх нь чухал байна. Тухайлбал, бид Сэлэнгийг Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн бүс нутаг болгоно гэж олон ч жил ярилаа. Одоо энэ асуудлыг ажил хэрэг болгож бодитой үр дүнд хүргэх хэрэгтэй байна. 2025, 2030 он гэхэд Сэлэнгийн тариаланчид хүссэн хэмжээндээ ургацаа тариад санасан хэмжээний ургац авчихдаг, нийт мал сүрэг нь ашиг шим арвинтай, захын айлын үнээ гэхэд 10-аас дээш литр сүүний гарцтай болчихсон, ард түмнийх нь амьдрал стрессгүй, амар амгалан хүүхэд залуус нь улсынхаа хэмжээнд сурлага, урлаг, спортоороо манлайлсан Монгол Улсынхаа хөгжлийн загвар аймаг болоод явж байна гэж төсөөлдөг дөө.

**-Ажлаа авснаас хойшхи амжуулсан гол ажлуудаасаа онцолбол?**

-Дээр хэлсэнчлэн аймгийнхаа гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд ихээхэн анхаарсан. Байгаль цаг уурын болоод эдийн засгийн үйлдвэрлэлийн хувьд ижил нэлээд хэдэн муж, хотуудтай хамтран ажиллах гэрээ хэлцэл байгууллаа. Зарим ажлууд эхнээсээ ажил хэрэг болоод явж байна. Үүний зэрэгцээ аймгийн төвдөө 50 мв-тийн дулааны цахилгаан станц шинээр барих ажлыг үндсэнд нь шийдвэрлэж одоо газраа сонгох, төсөв, төлөвлөгөө, техник, эдийн засгийн үндэслэлээ гаргах ажлууд хийгдэж байна. Энэ станц ашиглалтад орсноор аймгийн төвийн иргэд, айл өрхүүд өдөр шөнөгүй, өвөл зунгүй хэрэглээний байнгын халуун устай болох цаашлаад дулааны хүчин чадал нэмэгдэнэ, тэгснээр дахин төлөвлөлтийг шинэ станцтайгаа уялдуулан хийж, Сүхбаатар хотод амьдарч байгаа айлуудыг бүрэн хэмжээгээр дулаанаар доголдолгүй хямд үнээр халаах, үнэ одоогийн байгаагаасаа 35-40 хувиар буурах, шинээр баригдаж буй том объектуудаа халаах асуудлыг цогцоор нь шийдэх гэх мэтийн олон давуу талтай юм. Одоо байгаа манай уурын зуухны ашиглалтын хугацаа ерөнхийдөө дууссан, эвдрэл гэмтэл их гардаг, тоног төхөөрөмжүүд нь элэгдэж хуучирсан гээд зовлон тоочвол асуудал их. Тэнд ажиллаж байгаа ажлаа мэддэг инженер, үйлдвэрийн ажилтнууд л гал алдуулчихгүй авч яваа.


## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017.02.07
**Тендер шалгаруулалтын нэр:** “Багануур” ХК-ний 2017-2018 онд хэрэглэх сэлбэг материал нийлүүлэгчийг сонгох
**Тендер шалгаруулалтын дугаар:** СШУ №БНХК-2017-СМ/01-04/

“Багануур” эрх бүхий тендерт оролцогчдоос үйлчилгээний автомашины дугуй нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр иж бүрдэл бүрийг нь 50000 төгрөгөөр эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн хамт тендерийн нийт үнийн дүнгийн хоёр хувьтай тэнцэх дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны гуравдугаар сарын 10-ны өдрийн 09:30 цагаас өмнө доорх гурваг хаягаар ирүүлэх бөгөөд нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны гуравдугаар сарын 10-ны өдрийн 10:00 цагт Багануур ХК-ий захиргааны байранд нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.**

*Сонирхсон тендерт оролцогч тендерийн баримт бичгийг ажлын өдөр ажлын цагаар хаяг №1-ээс худалдан авах, тендертэй холбогдолтой мэдээллийг хаяг №2-оос авч болно.*

**Хаяг №1:** Улаанбаатар хот. Баянзүрх дүүрэг. “Багануур” ХК-ний төлөөлөгчийн байр. Төлөөлөгч Р.Энхбаатар Утас : 70157719,99098715,99023137, Факс : 70157719
**Хаяг №2:** Техникийн бодлогын хэлтсийн дарга Х.Хашбат Утас : 70210351 Худалдаа хангамжийн менежер Ч.Чулуунбат Утас: 70210927, Факс : 70210364
**Хаяг №3:** Багануур дүүрэг. “Багануур” ХК-ийн захиргааны байр. 304-н тоо Худалдаа хангамжийн менежер Ч.Чулуунбат Утас: 70210927

**БАГАНУУР ХУВЬЦААТ КОМПАНИ**

## ЦАГ ҮЕ

# ДЭМЖИЖ АЖИЛЛАНА

**-Таныг залуусаа дэмжсэн олон чухал шийдвэрүүдийг гаргасан гэж ярих юм билээ?**

-Сэлэнгэ аймгийн нэр, алдрыг дуурсгах авьяас, чадвартай олон сайхан залуучууд зөвхөн Сэлэнгэ гэлтгүй Монгол орныхоо нэрийг гаргаж тив, дэлхийн тэмцээн уралдаанд явах гэхээр санхүүгийн асуудал тулгамддаг. Тэр бүгдэд аймгийнхаа зүгээс чадах хэмжээгээрээ л туслах, дэмжихийг зорьж байна. Эдгээр залуучууд итгэлийн хариуд ганзага дүүрэн эргэж уулзаж байгаа нь сайхан юм. Ер нь ирэх жилүүдэд спорт, эрүүл мэндийн салбарыг анхаарлынхаа төвд байлгана гэж дээр хэлсэнчлэн энэ салбарынхантайгаа их ойр байна гэж бодож байгаа шүү.

**-Сэлэнгэ аймаг газар тариалангийн гол үйлдвэрлэгч аймаг. Газар тариалан хөгжихийн хэрээр мал аж ахуйтайгаа зөрчилдөх асуудал ихэссэнийг үе үеийн Засаг дарга нар бүгд л ярьдаг байсан. Газар тариалангийн бүс нутгийн хувьд энэ асуудлаа зохицуулахад аймгийн зүгээс тодорхой бодлого барин ажиллаж байгаа байх. Таны бодлоор цаашид ямар төвшинд байлгавал зүгээр юм бол?**

-Энэ асуудлыг шийдвэрлэх гаргалгааг үйл ажиллагааны хөтөлбөртөө оруулсан байгаа. Сэлэнгэ аймаг хэзээнээсээ газар тариалангийн бүс нутаг байж ирсэн түүхтэй. Манай аймгийн анхны нэр хүртэл "Тариалангийн аймаг" шүү дээ. Тэгэхээр бид улсынхаа өмнө монгол түмнээ экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнээр хангах үүрэг хүлээсэн улс. Энэ үүргээ нэр төртэй биелүүлж явахын тулд жил бүр ургац алдахгүй, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх хэрэгтэй юм. Нэгдэл САА-н үед Сэлэнгэ аймгийн мал сүрэг 700-800 мянган тоо, толгойд л байсан гэдэг. Одоо нэг дахин нэмэгдээд 1.6 саяд хүрчихсэн байгаа. Энэ тоо толгойн өсөлтөд олон хүчин зүйл нөлөөлж байгаагийн нэг нь өөр аймгуудаас ялангуяа баруун аймгуудаас шилжиж ирэгсэд зохиомол өсөлтийг бий болгоод байна. Тэгэхээр бид одоо Үндсэн хуульд заасан "Хүн бүр оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй" гэсэн заалтыг хэрэгжүүлэхээс өөр аргагүй болж байна. Энэ заалтад хүн бүр гэсэн болохоос хүн бүр малтайгаа хамт гээгүй байгаа биз дээ. Тэгэхээр хэрэв та Сэлэнгэ аймгийн иргэн болох гэж байгаа бол наад олон малаа тэр борлуулах газарт нь борлуулаад ир ээ. Тэгээд манай аймгаас өндөр ашиг шимтэй малаа худалдаж аваад амьдарч болно гэх юм. Өөрөөр хэлбэл тооны араас биш чанарын араас амьдар гэж малчиддаа ойлгуулах нь чухал байна. Байдлыг анзаараад байхад газар тариалан, мал аж ахуй хоёр үнэхээр л таарч өгөхгүй байгаа. Тариаланчид маань өр, зээл тавиад тухайн газартаа ихээхэн хэмжээний хөрөнгө хаяж байж арвин ургац авдаг жамтай. Ургацаа авахаас нь өмнө олон малын хөл талбайг нь сийрүүлж, хамаг үржил, чийгийг нь агаарт замхруулаад хаячихдаг. Тэгээд л өнөөх ургацын хэмжээ буурна. Ингээд байхаар хэн дуртай байх вэ дээ.

**-Ний нуугүй ярихад гаднаас ирж байгаа олон тооны малтай айлуудыг өөхшүүлээд нутагшуулаад байгаа хэргийн эзэд нь зарим баг, сумын дарга нар. Тэд асуудлыг нуудаг гэхмэтчилэн. Энэ таны анхааралдаа авах асуудлуудын нэг байх?**

-Энэ чиглэлд сумдынхаа дарга нарт тодорхой үүрэг, даалгавар өгч хяналт тавьж ажиллана. Өөр аймгуудаас ирж байгаа мал манай аймгийн малын тоо, толгойг зохиомлоор өсгөхөөс гадна улирлын болоод цаг үеийн тарилга, туулгадаа хамрагдсан эсэх нь тодорхойгүй, энэ нь эргээд гоц халдварт өвчин гаргах магадлалыг ихэсгэдэг. Тиймээс энэ талд онцгой анхаарах зайлшгүй шаардлага байна. Тухайн нутгийн иргэдийн оролцоо, хяналт бас их чухал гэдгийг онцлон хэлмээр байна. Аймгийн Засаг даргын Тамгын газарт иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах зориулалттай 7036-1111 утас ажлын цагаар байнгын ажиллагаатай ажилладаг. Үүгээр дамжуулаад ч юм уу холбогдох хүмүүст манай сум, багийн нутагт тэр аймгаас тийм хэмжээний малтай өрх, зөвшөөрөлгүйгээр ирсэн гэж тухай бүр нь мэдээлж ажиллах юм бол бид асуудлыг шуурхай шийдвэрлэж ажиллана.

**-Сүүлийн үед хот гэлтгүй орон нутагт ч агаарын бохирдол үүсэх магадлал өндөр байна. Тэр тусмаа өвлийн улиралд. Сэлэнгэ аймгийн хүн ам нэмэгдэж, хүрээгээ тэлсээр байна. Бага ч гэлтгүй агаарын бохирдлын асуудлыг яаж шийдвэл зүгээр юм бол?**

-Энэ асуудлыг бид цаг алдахгүй шийдвэрлэхийн төлөө, барьж авах нь чухал болоод байна. Нэгэнт дийлэхгүй хэмжээнд асуудлыг хүргэвэл ямар болох вэ гэдгийг Улаанбаатар болоод Дархан-Уул аймгийн жишээн дээр тод харж болохоор байна шүү дээ. Тэгэхээр өнөөх нэгдсэн нэг халаалттай болох Дулааны цахилгаан станцын тухай эргээд ярих хэрэгтэй болж байна. Аймгийн айл, өрхүүд 21-р зуунд тус тусдаа галаа түлж утаа үйлдвэрлээд байх уу, эсвэл нэгдсэн нэг халаалттай, цэвэр бохир устай, тохилог байранд амьдрах уу. Ийм л үүднээс энэ станцыг ажил болгоё гэж зориод байгаа юм. Цаашлаад хүн амын төвлөрөл ихтэй Мандал, Сайхан сумдын шинэ удирдлагууд үйл ажиллагааны хөтөлбөртөө утаагаа бууруулах, багасгах талаар тодорхой асуудлууд тусгасан байх гэж бодож байна. Асуудлаа оновчтой тодорхойлоод ажил хэрэг болгоё гээд ирвэл аймгийн зүгээс бүх талаар нь дэмжиж ажиллана. "Бид хийхгүй бол хэн хийх вэ, одоо хийхгүй бол хэзээ хийх вэ" гэдэг үг байдаг даа. Энэ үг өнөөдөр яг энэ асуудалд зориулагдсан гэж ойлгохоор байна.

**-Хот хөдөөгүй яригддаг асуудлын нэг бол сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ хангамж. Аймгийн хувьд энэ байдал ямар төвшинд байна вэ? Ирэх жилүүдэд шинээр ашиглалтад орох сургууль, цэцэрлэгийн тухайд?**

-Сэлэнгэ нутгийнхаа хөгжилд хувь нэмрээ оруулах зөв хүнийг төлөвшүүлэх анхны алхам бол сургуулийн өмнөх боловсрол буюу цэцэрлэгийн хүмүүжил юу юунаас илүү чухал. Хүүхдээ гэртээ цоожлоод ажлаа хийж байгаа хүн ажилдаа анхаарлаа хандуулж амжилттай ажиллах нь юу л бол. Тиймээс бид ирэх жилүүдэд Сэлэнгэ аймагт шинээр барилга, орон сууц баригдах юм бол нэг давхарт нь цэцэрлэгийн асуудлыг хамт шийдэх Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана. Үүний эхлэл болгож манай аймгийн нутагт үйл ажиллагаа явуулдаг "Болд төмөр ерөө гол" ХХК нийгмийн хариуцлагынхаа хүрээнд Ерөө сумын төвд баригдсан таван давхар орон сууцны нэг давхрыг худалдан авч цэцэрлэгийн зориулалтаар тохижуулж суманд нь хүлээлгэн өгөөд байна. Энэ бол ирээдүй болсон хүүхэд багачуудынхаа төлөө хийж байгаа буянтай ажил юм гэж ойлгож байгаа. Одоо аймгийн төвд баригдсан 10 давхар байрны нэг давхрыг цэцэрлэг болгох асуудлыг судлаж байна. Мөн Мандалд ч гэсэн адил. Энэ жил л гэхэд хэд хэдэн цэцэрлэгийн байр шинээр ашиглалтад орж байгаа. Энэ мэтчилэн асуудлуудыг алхам алхамаар шийдээд явна.

**-Үзэсгэлэнт сайхан байгал, түүх соёлоороо бас л онцлог нутаг даа?**

-Манай аймаг чинь гурван мэргэдийн нутаг гэдгээсээ эхлээд түүх соёлын дурсгалт болоод байгалийн үзэсгэлэнт газрууд ихтэй. Зөвхөн байгалийн сайхнаар тогтохгүй ховор болон нэн ховор ан амьтад, жимс, жимсгэнэ гээд бүх л зүйл байна. Тэгэхээр бид энэ сайхан газар нутагт төрснөөрөө үргэлжид бахархаж явах ёстой шүү. Монгол хүн бүрийн зорьж ирдэг "Ээж мод" түүхийн үнэт "Амарбаясгалант", "Сайхны хөтөл", "Ерөөгийн халуун рашаан" гээд яриад байвал зөндөө дөө. Эрт дээр үеэсээ бахархах үүх түүхтэй Хулан хатан, Ханын хөндий, Оргидог булаг, Алтан арал гээд энэ бүх боломжоо бид бүрэн дүүрэн ашиглаж байгалийн унаган төрхийг нь алдагдуулахгүй хамгаалах, зах зээлийн эргэлтэд буюу аялал жуулчлалын урсгалыг татах нь чухал байна. Энэ салбар хөгжих боломж, онцлог нь дэд бүтцийн давуу тал, газар нутгийн байршил байна. Үүндээ түшиглээд ажлын байр бий болгох, аймгийнхаа төсвийг зузаатгах гээд бодож, санаж байгаа ажлууд их байна.

**-Сэлэнгэ аймаг Монгол улсын тэргүүний аймаг. Энэ амжилтаа хадгалан цаашид хөгжлийн шинэ төвшинд хүрэхийн төлөө ажиллахыг танаас Сэлэнгийн ард иргэд харж хүлээж байгаа байх гэж бодож байна?**

-Манайх чинь есөн удаа улсынхаа шилдгээр шалгарч байгаа бахархам амжилттай аймаг. Дээрээс нь төрийн гурван одонтой анхны аймаг. Энэ амжилтуудыг гаргахад айл бүр нь ажилсаг, өрх бүр нь үйлдвэрлэгч ард иргэдийн маань оролцоо чухал байсан нь тодорхой. Энэ ч утгаараа би 2016-2020 оны үйл ажиллагааны эрхэм зорилгоо "Хамтын зүтгэлээр эх нутгаа хөгжүүлье" гэж тодорхойлсон юм. Хүн бүр л өмнөө тавьсан зорилтоо, хариуцсан ажлаа ямар нэгэн асуудалгүй, сэтгэлээсээ хийгээд байвал амжилтад хүрнэ гэж би боддог. Тэгээд аймгийн удирдлагын хувьд хийе, бүтээе гэсэн хэнийг ч болов аймгийнхаа боломж, бололцооныхоо хэмжээнд дэмжиж, хамтарч ажиллана гэдгээ үүгээр дамжуулаад хэлэх байна даа.

**-Өвлийн сар гарснаас хойш цас нэлээдгүй орлоо. Аймгийн өвөлжилтийн байдал хамгийн тулгамдсан асуудал болоод байна. Өвлийн бэлтгэлээ ямар төвшинд базаасан байгаа вэ?**

-2016-2017 оны өвөлжилт манай аймгийн хэмжээнд бас ч гэж тийм ч амар амгалан биш байна. Цаг хугацааны хувьд эрт их хэмжээний цас орж бог мал үндсэндээ бэлчээрлэх боломжгүй болсон. Дээрээс нь нийтийн сэтгэл зүйд бичин жил гэсэн айдас сууж, уулархаг бүсийн есөн сум цас ихтэй байна. Манай аймгийн үндсэн малчид, мал бүхий иргэд бол хэзээнээсээ хадлан, тэжээлээ бэлдээд сурчихсан улс. Хэр барагтай цас бороонд яарч сандраад байдаггүй. Гэсэн хэдий ч байдал ийм байгаа үед бид малчдаа анхаарч, аймгийнхаа эрүүл мэндийн газраас баг гарган сумдад ажиллуулж байна. Малчин иргэд маань сум, аймгийн төв ороод эрүүл мэндээ үзүүлчих цаг завгүй л хөдөлмөрлөдөг улс. Тийм учраас байгаа газар нь, хотонд нь очиж айл саахалтаар нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлье гэж зорьж байгаа юм.

**-Одоо хувь хүн талаас чинь ярилцмаар байна. Та өөрийгөө товчхон тодорхойлооч?**

-Миний хувьд Сэлэнгэ нутгийн эгэл жирийн нэгэн сэхээтэн айлын бага хүү. Ээж аавaас тавуулаа. Гурван эгч, нэг ахтай. Сэлэнгэ аймгийн Шаамар суманд төрж, цэцэрлэг болон сургуульд аймгийнхаа төвд сурч, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийг дулааны инженер, ИЗИС-ийг эрх зүйч мэргэжлээр төгссөн. Шаамар, Сүхбаатар сумд газар нутгийн хувьд их ойрхон болохоор хоёр сумынхаа хооронд л гүйж, тоглож өссөн дөө.

**-Та Сэлэнгэ нутгийн унаган хүүхэд, бага насны сайхан дурсамжаасаа хуваалцаж болох уу?**

-Манайх аймгийн захиргааны зүүн талын ягаан хоёр давхарт байсан юм. Тэгээд "Сэлэнгийн долгио" чуулга, II сургууль, "Алтанбулаг" кино театр гээд л энэ л хавиар миний бага нас өнгөрсөн дөө. Өнөөдөр хажууханд нь ажиллаж, амьдарч байна. Хааяа цонхоороо хараад бага насаа бодохоор бас сайхан байдаг.

**-Аав, ээжийнхээ тухай ярьвал?**

-Миний аав Цэндсүрэнгийн Шархүү гэж Монгол Улсын болон ОХУ-ын Буриад Улсын Гавьяат жүжигчин, "Сэлэнгийн долгио" чуулгад насаараа дуулсан хүн дээ. Ээжийг маань Өлзийтогтохын Одончимэг, Хушаат сумын уугуул, Монгол хэл, уран зохиолын багш мэргэжилтэй, мөн л насаараа боловсролын байгууллагад ажиллаж байсан. Одоо манай хоёр гэртээ ач зээ нартайгаа шуугилдаад л байж байдаг юм.

**-Нэгэн уламжлалт гэмээр асуулт байдаг. Амжилттай яваа хүний ард сайн хань гэдэг?**

-Тэгэлгүй яах вэ. Ар талдаа санаа зовох зүйлгүйгээр өмнөх ажилдаа анхаарч байж л их бага гэлтгүй ажил амжилтад хүрнэ гэдэгтэй 100 хувь санал нэг байдаг. Намайг энэ зэрэгтэй явахад миний ханийн оролцоо юу юунаас чухал. Эхнэрийг маань Ариунжаргал гэдэг. Бид аймгийн Гаалийн газарт байхдаа анх танилцаж билээ. Намайг Гаалийн газраас гарч Сэлэнгэ Энергод очихоос нэг сарын өмнө манай хүн Сэлэнгэд хуваарилагдаад ирж байсан юм. Одоо бид нэг хүүтэй. Хүү маань аавынхаа сурч байсан II сургуульд сурч байна.

**-Таныг бас шаггүй тамирчин гэдгийг мэдэх юм байна?**

-Миний хувьд бүх л төрлийн спортыг өөрийнхөө хэмжээнд сонирхдог, ялангуяа сагс, волейболд дуртай. Спортын олон найз нөхөдтэй. Анх спортод хөл тавиулсан хүн бол Дугарсүрэнгийн Оюунболд гэж Монгол Улсын гавьяат тамирчин, Москвагийн олимпийн хүрэл медальт Монголын төдийгүй дэлхийн данстай сайхан хүн байлаа. Би багш дээрээ анх чөлөөт бөхийн спортоор хичээллэж тавдугаар ангиасаа аравдугаар ангиа төгстлөө явсан. Манай ангийнхнаас олон сайхан тамирчид төрөн гарсан.

**-Таны бахархал?**

-Эцэг эх маань юуны түрүүнд миний бахархал. Энэ хоёр маань намайг хүний орчлонд эрүүл саруул төрүүлж өсгөж, эрдэм боловсрол эзэмшүүлсэн ачтангууд минь. Мөн дээрээс нь эцэг, эхийн багаас олгосон хүмүүжил минь бас миний өдий зэрэгтэй явахад ихээхэн тус дэм болж байгаа болов уу гэж бодож байна.

**-Хэлэх дуртай үг?**

-"Санаа зөв бол заяа зөв" энэ их сайхан үг гэж боддог. Аливаа бүхэнд сайн сайхан санаад явж байхад ажил төрөл аандаа бүтээд, найз нөхөд, хамт олонтой явдаг юм байна гэж дотроо боддог доо.

**-Сүүлийн жилүүдэд таны хурдан хүлгүүд аймаг, бүсийн наадмуудад олон түрүү, айраг авч байгаа байх аа?**

-Монгол эр хүн болж төрсний хэрэг юу билээ, энэ сайхан уудам тал, үзэсгэлэнт нутгийн эзэд бид өөр бусад орон, улсуудаас ялгарах, бахархах эрийн гурван наадамтай түмэн. Түүний нэг нь төрийн сүлдэнд заларсан молор эрдэнэ болсон морь минь гэж ойлгодог. Би ч зарим уяачдыг бодвол хожуу морьтой "нөхөрлөсөн". Гэсэн хэдий ч сайхан хурдан буянгууд, сайн уяач ах таарч сүүлийн жилүүдэд аймагтаа сайхан наадаж байна. Манай морьдын уяа сойлгыг аймгийн алдарт уяач Д.Эрдэнэбат ах маань тааруулдаг. Сэлэнгийнхэн Бужгаа гэхээр нь андахгүй дээ. Өнөө зуны наадмаар аймгийн алдарт уяач цолны болзлоо хангасан байсан. Тэгээд наадмын дараа ажлаа авахдаа С.Бүрэнбат даргатайгаа бид хэд ярьж сууж байсан чинь С.Бүрэнбат дарга сайхан мэдээ байна штээ, тэгвэл дараа нь ямар өөрөө өөртөө шийдвэр гаргаад аймгийн цолоо авалтай биш дээ, ерөөсөө би отгон захирамжаа болгоод цолыг чинь олгоноо гээд энэ хүндтэй цолыг авсан байгаа. Цол авах нэг хэрэг, цолоо дааж явах бас нэг хэрэг байх. Тиймээс хурдан хүлэг морио уралдуулж Монгол түмнээ баясгах, Монгол соёлоо ирээдүйн залуустаа өвлүүлэх үйл хэрэгтээ зүтгэнээ л гэж бодож байгаа.

---

*Аймгаас мэдээлж байна*

СЭЛЭНГЭ АЙМАГ



### Сэлэнгэ аймагт 320 тонн өвс үнэ төлбөргүй олголоо

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Шадар сайд, Улсын Онцгой комиссын дарга У.Хүрэлсүхээр ахлуулсан ажлын хэсэг Сэлэнгэ аймгийн өвөлжилт хүндэрсэн сумдад ажиллалаа. Тус ажлын хэсгийн гол зорилго Сэлэнгэ аймгийн өвөлжилтийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, онцгой комисст заавар зөвлөгөө өгөх, тулгамдсан зарим асуудлуудыг шийдвэрлэхэд оршиж байв. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд УИХ-ын гишүүн Н.Оюундарь, ХХААЯ-ны дэд сайд Ж.Сауели, Улсын Онцгой комиссын нарийн бичгийн дарга, хурандаа Н.Энх-Амар, Шадар сайдын зөвлөх А.Үйлстөгөлдөр, Л.Алтангэрэл, МХЕГ-ын дарга Н.Цагаанхүү нарын албаны хүмүүс багтаж байлаа. Баг бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга, аймгийн онцгой комиссын дарга Ш.Оргил тэргүүтэй аймгийн онцгой комиссын бүрэлдэхүүн хүлээн авч, Мандал, Баянгол, Сүхбаатар, Зүүнбүрэн, Цагааннуур сумдын өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцууллаа. Улсын нөөцөөс манай аймагт 320 тонн өвсийг үнэ төлбөргүй, 240 тонн тэжээлийг 50 хувиар хямдруулан олгоод байна.

ДАРХАН-УУЛ АЙМАГ

### Алслагдмал сумдын 87 өрхөд тусламж үзүүлэв

Дархан-Уул аймгийн нийт нутгаар битүү цасан бүрхүүл тогтож, хөдөө аж ахуйн цаг агаарын байдал сөргөөр нөлөөлж, өвөлжилт хүндрэх төлөвтэй болж байгаатай холбогдуулан аймгийн удирдлагууд дөрвөн ажлын хэсэгт хуваагдан малчдаар явж эхэлсэн. Аймгийн Засаг дарга С.Насанбат тэргүүтэй ажлын хэсэг Хонгор сум, Шарын гол сумын алслагдсан малчин өрхөөр нэгдүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн орж цаг үеийн байдалтай газар дээр нь танилцсан юм.

Малын бэлчээрийн цасан бүрхүүлийн зузаан, нягт тодорхойлох, малчдад эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, малчдад зарим нэгэн шаардлагатай эд зүйлсийн дэмжлэгийг энэ үеэр өгч малчин, мал бүхий иргэдийн санал хүсэлтийг сонслоо. Улмаар хоёр өдрийн турш нийт Хонгор, Шарын гол сумын алслагдсан цэгт амьдарч байгаа 87 өрхөд нийтдээ 160 боодол өвс, 254 шуудай хивэг, 240 шуудай нүүрс, 200 ширхэг элгэвч, нэмнээ, эмийн сангуудын "Эм холбоо"-ноос хандивласан 15 багц анхан шатны тусламж үзүүлэхэд шаардлагатай эм хэрэгслийг малчдад хүргэсэн байна.

Улсын нөөцөөс тодорхой хэмжээний өвсийг үнэ төлбөргүй, тэжээлийг 50 хувийн хямдралтай олгох шийдвэрийг улсын онцгой комиссоос гаргасан бөгөөд малчид өөрсдөө өвс тэжээлээ авах боломжтой юм байна. Мөн энэ сарын 5-наас эхлэн Хүнс хөдөө аж ахуйн газраас холбогдох мэргэжилтэн, малын эмч нар малчдаар явж малыг вакцинжуулахаар болжээ. Цаашид малчид руу чиглэсэн хандив тусламж, алслагдсан, хүн хүч муутай малчдад туслах ажлыг өрнүүлэхээр боллоо.

БУЛГАН АЙМАГ



### "Монгол нум сум" дэд хөтөлбөрийг баталлаа

Булган аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид "Монгол нум сум" дэд хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлэхээр баталсан байна. Дэлхийн соёлын үнэт өв болон тэмдэглэгдсэн эрийн гурван наадмын нэгэн төрөл Монгол үндэсний сурын харвааг өвлүүлэн уламжлах, эрийн гурван наадмыг хөгжүүлэх, үндэсний сурын харвааны ойлголт, дэг соёлыг нийтэд түгээх, спортын хэрэглээг нэмэгдүүлэх, нум сум, сурын харвааны материаллаг баазыг бэхжүүлэх зорилгоор энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж аймгийн хэмжээнд сурын спортоор хичээллэгсдийн тоог гурав дахин буюу 600-д хүргэх юм байна. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж ирэх гурван жилд улс, орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээс 121.4 сая төгрөг зарцуулахаар төлөвлөжээ.

Аймгийн баяр наадамд сурын харвааны төрлөөр Бүрэгхангай, Хишиг-Өндөр, Булган зэрэг 11 сумаас харваачид тогтмол оролцож, эдгээр суманд нийтдээ 224 иргэн сурын харвааг сонирхон хичээллэдэг байна. Үндэсний сурын спортын уламжлалыг Бүрэгхангай сумынхан авч явдаг бөгөөд аймаг сумын наадмын түрүүг алддаггүй гэхэд хилсдэхгүй. Зөвхөн тус суманд аймгийн цолтой 10, спортын мастер, спортын дэд мастер цолтой найман харваач байдаг аж. Түүнчлэн аймгийн хэмжээнд үндэсний сурын харвааны холбоогоо ч байгуулаагүй эрийн гурван наадмын нэг төрөл сурын спортыг хөгжүүлэхээр "Монгол нум сум" хөтөлбөрийг баталжээ.

NO STRESS

УРАН БҮТЭЭЛЧ



Б.СУМЪЯА

*"Монгол контент", "Хамба фильм" студийн хамтын бүтээл "Хоёр амь" киноны гол дүрд тоглосон загвар өмсөгч, жүжигчин Д.Пүрэвсүрэнтэй цөөн хором ярилцлаа.*

# Д.Пүрэвсүрэн:

## Адал явдалт кинонд тулаанч эмэгтэйн дүр бүтээхийг мөрөөддөг

**-Гол дүрд нь тоглосон "Хоёр амь" кино нээлтээ хийсэн. Хамтарч ажилласан кино группийнхээ талаар яриач. Өмнө нь ер нь хамтарч ажиллаж байв уу?**

-"Хамба фильм" студийн Б.Ганболд буюу Тука найруулагчтай анх удаа л хамтарч ажиллалаа. Жүжигчин С.Болд-Эрдэнэ, гэрэлтүүлэгч, зохиолч, продюссер гээд бүх л хүмүүс миний өмнө нь хамтарч ажиллаж үзээгүй шинэ групп байсан. Шинэ багтай хамтарч ажиллахад шинэ танил, шинэ бүтээлийн хаалга нээгдэж байдаг. Тийм учраас сурах зүйл ч маш их байлаа. Жүжигчин С.Болд-Эрдэнэ ахын хувьд хамтран тоглогчоо чиглүүлж өгдөг чадварлаг жүжигчин. Тука найруулагч ч аливааг бусдаас өөр өнцгөөс харж, түүнийгээ өвөрмөцөөр илэрхийлдэг.

**-"Хоёр амь" кинонд ямар дүр бүтээв. Өмнө нь үзэсгэлэнтэй, гал цогтой эмэгтэйчүүдийн дүрд тоглож байсан шүү дээ. Харин энэ удаад?**

-Зохиолч эмэгтэйн дүрд тоглосон. Өмнө нь ихэвчлэн гоё сайхан эмэгтэйн дүрд тоглодог байсан бол энэ удаа тэс өөр эмэгтэйн дүр дээр ажиллалаа. Эгэл жирийн, үнэний төлөө гэсэн эрмэлзэлтэй тийм л энгийн эмэгтэйн дүрд тоглосон. Найруулагч анх санал тавихдаа л "Чи энэ кинонд хөөрхөн, гоё харагдахгүй. Тиймээс гадаад төрхөндөө анхаарах шаардлагагүй" гэж билээ. Тэр ч утгаар кинонд тоглохдоо нүүрээ ч будаагүй. Надаас тэс өөр араншинтай хүний дүр байлаа. Би чинь байнга л инээж явдаг хүн. Гэтэл найруулагч "Битгий инээ. Наад нүднийхээ харцыг буулга. Ийм гал цогтой байж болохгүй" гээд л зааварладаг байсан. Найруулагчийн хэлсэн зааврын дагуу л дүр дээрээ ажилласан. Мэдээж тодорхой хэмжээний хичээл зүтгэл гаралгүй яах вэ.

**-Дүрийнхээ талаар цухасхан дурьдвал?**

-Миний тоглосон дүр уг нь нэг амь аврахын төлөө яваа бүсгүйн дүр. Гэтэл хөндлөнгөөс харахад, эсрэг дүр ч юм шиг. Хүмүүс үзээд л өөр өөрсдийнхөөрөө ойлгох байх.

**-"Хоёр амь" киноноос үзэгчид юуг мэдрээсэй гэж хүсч байна вэ?**

-Үзэгчид өөр өөрсдийнхөөрөө л дүгнэх байх. Үүнийг л ойлгоод аваарай гэж хэлэхийг хүсэхгүй байна. Гэхдээ амь гэдэг үнэтэй. Хүний амь, амьтны амь, баян ядуу хөрөнгө чинээ хамаагүй ээ, зүгээр л амь гэдэг юу юунаас илүү үнэтэй зүйл шүү гэдгийг харуулж чадсан кино болсон.

**-Дараагийн уран бүтээлийн төлөвлөгөө юу байна вэ?**

-Төлөвлөгөө мэдээж байлгүй яах вэ. Гэхдээ мэргэжлээсээ хөндийрөхгүй. Үргэлж мэргэжлийнхээ ажлыг хийх болно. Яг одоогоор кинонд тоглоогүй байгаа. Гэхдээ яригдаж буй уран бүтээл бий. Энэ ондоо багтаад шинэ уран бүтээлийнхээ ажилд орно.

**-Таны хувьд буян гэж юу вэ?**

-Миний бодлоор буян гэж хариу нэхдэггүй чин сэтгэлийн тусыг хэлдэг юм болов уу.

**-Уран бүтээлд хэр цензур тавьдаг вэ. Төдийлөн олон кинонд тоглоод байдаггүй. Сонгож буй бүтээлдээ цензур тавьдаг юм шиг санагддаг?**

-Жилд хэдэн кинонд тоглохдоо биш, чанартай бүтээлд л дүр бүтээх юмсан гэж боддог. Ямар тоо бөглөх гэж байгаа биш дээ. Нэг, хоёр жил хүлээсэн ч хамаагүй чансаатай уран бүтээлд тоглоно гэж боддог.

**-Ер нь таны мөрөөдлийн дүр чинь юу вэ?**

-Адал явдалт кинонд тулаанч эмэгтэйн дүр бүтээж үзэхийг мөрөөддөг болсон. Хэзээ нэгэн цагт миний мөрөөдөл биелэх байх. /инээв/

Улаанбаатарт:



Маргааш

Өдөр -15
Шөнө -27

Нөгөөдөр

Өдөр -13
Шөнө -24

Өдрийн зурхай

**ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САР ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН ҮХЭР ӨДӨР**

**Наран ургах шингэх:** 08.12-18.02
**Үс засуулбал:** Эрхтэн хурц болно
**Барилдлага:** Үхэх
**Шүтэн барилдлага:** Төрөхүй



*Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Гэрийн үйл, бие угаах, хувцас өмсөхөд сайн. Баруун нүд татвал зочин ирэх, зүүн нь татвал хувцас олдох, баруун чих цангинавал баярлах, зүүн нь бол муу. Нохой уливал амгалан сайн болох, тагнай загатнавал дээрэм ирэх, бие татвал аюул болно. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой.*

ДУУЛГАХ СОНИН

## Говийн зургаан гайхамшгийг хамгаалах машин хүлээлгэн өглөө







Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Б.АЛТАНБАГАНА

Монголын бартаат замын авто холбооноос санаачилсан "Гайхамшигт зургаагийн төлөө" төслийн хүрээнд үйлчилгээний УАЗ 469, УАЗ Фургон, Ландкруйзер 79 гэсэн гурван машиныг бүрэн засварлаж, БОАЖЯ, "Мазаалай хамгаалах сан"-д хүлээлгэн өглөө. Автомашин хүлээлгэн өгөх ёслолын үеэр Монголын бартаат замын авто спортын холбооны тэргүүн Т.Ганболд "Говийн их дархан цаазат газарт хар сүүлт, буга, тахь, хавтгай, хулан, мазаалай гэсэн зургаан гайхамшигт амьтан байдаг. Тэдгээр амьтдыг хамгаалахад тулгамдаж буй нэг том асуудал нь машин техник. Дэлхийд ховордсон эдгээр амьтдаа хайрлаж, хамгаалах үүднээс олон хүмүүс сэтгэл зүрх нэгдэж ажилласан. Энэхүү ажлын хүрээнд гурван машиныг бүрэн гүйцэд тоноглож, хүлээлгэн өгч байгаадаа баяртай байна" гэж хэллээ. Тус үйл ажиллагаанд 150 хүн оролцсон бөгөөд гурван машиныг засварлахад 30 гаруй сая төгрөг зарцуулсан ажээ. Мөн Говийн их дархан цаазат газарт зориулж 100 гаруй анхааруулах тэмдэглэгээг хийсэн юм байна.

## "Сэтгэлийн 1000 донор" аянд тамирчид нэгдлээ




Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу сар бүрийн 3-ны өдрийг ЦССҮТ-өөс "Цусаа бэлэглэх өдөр" болгон зарласан билээ. Уламжлал болсон уг арга хэмжээ 2017 оны хоёрдугаар сарын 3-нд ЦССҮТ-ийн шинэ байранд боллоо. Хоёрдугаар сард Монголын уламжлалт цагаан сарын баяр тохиодог учир ЦССҮТ-өөс цусаа бэлэглэх аянг "Сэтгэлийн 1000 донор" уриан дор энэ сарын турш үргэлжлүүлэх болсноо зарлалаа. Цаг үеийн онцлогоос шалтгаалан өнгөрсөн жил ч ийм аян зохиосон бөгөөд "Сэтгэлийн 1000 үйлс" хэмээх нийгэмд үйлчлэх ТББ хоёрдахь жилдээ хамтран тэмдэглэж байгаа юм. Мөн Д.Гүрсэд захиралтай "Прайд трейдинг" ХХК, Монголын үндэсний сагсан бөмбөгийн холбоо (МҮСБХ) дэмжиж оролцохоо илэрхийллээ. Энэхүү сарын аяны хүрээнд МҮСБХ-ны "Sprite league"-ийн тамирчид цусаа бэлэглэх аж. Мөн Н.Баасандамба, Д.Даваажаргал, Н.Алтантуяа нарын хүндэт доноруудад "Хүрэл донор" өргөмжлөл гардуулж, Б.Буянтогтох, А.Эрдэнэболд нарыг "Бахархлын тэмдэг 10" тэмдгээр, Ж.Даваадагва, Ц.Наранбаатар нарыг "Бахархлын тэмдэг 20" тэмдгээр тус тус шагнаж урамшууллаа.

## Монголын сагсан бөмбөгийн холбооны бүртгэлийг хүчингүй болгожээ

Монголын сагсан бөмбөгийн холбооны бүртгэлийг хүчингүй болгожээ. Монголын сагсан бөмбөгийн холбооны ээлжит их хурал өнгөрсөн онд болсон. Уг хуралд 300 орчим төлөөлөгч сагсан бөмбөгийн тамирчин, дасгалжуулагч, зүтгэлтнүүд оролцохдоо энэхүү спортоос төрсөн анхны гавъяат гэгдэх дасгалжуулагч Ц.Цэвэрбалыг ерөнхийлөгчөөрөө сонгожээ. Улмаар Монголд гудамжны сагсан бөмбөгийг анх дэлгэрүүлсэн Монголын үндэсний сагсан бөмбөгийн холбоотой хамтран үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. Тэгвэл иргэн Б.Оргилын хүсэлтийн дагуу өнгөрсөн сарын 18-нд Ц.Цэвэрбал ерөнхийлөгчтэй Монголын сагсан бөмбөгийн холбооны улсын бүртгэлийг албан ёсоор хүчингүй болгожээ.

Энэ талаар тус холбооны удирдах зөвлөлийн гишүүн Р.Цэвэгмэд хэлэхдээ "Хэсэг хүн манай холбооны бүртгэлийг зориудаар бүртгэлгүй болголоо. Эрх мэдэлд шунасан, нэр хүнд хөөсөн тэр хүн Э.Анар. Түүнийг спортын хүрээнийхэн сагсан бөмбөгийн тамирчин байсан, МАН-ын дарга М.Энхболдын хүү гэдгээр нь андахгүй. Монголын сагсан бөмбөгийн холбоо дөрвөн жил шүүхээр явсны эцэст холбооны ерөнхийлөгчөө сонгож, холбоогоо сэргээсэн. Гэтэл эрх мэдлээ ашиглан хэсэг хүн Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт нөлөөлж бидний хийсэн ажлыг уландаа гишгэлээ. Үнэхээр Монголын сагсан бөмбөгийн холбоог шинэчилж, спортоо аврах хүсэлтэй байгаа бол хамтарч ажиллах санал тавьсан ч бидэнд татгалзсан хариу өгсөн. Тэгсэн атлаа зөвхөн өөрсдийн эрх ашигт нийцүүлсэн холбоотой болохын тулд өмнөх холбооны эрхийг хууль бусаар, хүч түрэмгийлэн цуцалсанд харамсч байна. Монголын сагсан бөмбөгийн холбоо, Үндэсний сагсан бөмбөгийн холбоо хамтран үйл ажиллагаа явуулсанаар тамирчдын амжилт нэмэгдсэн. Өнгөрсөн онд л гэхэд олон улсын найман тэмцээнд оролцохдоо долоон медаль авлаа. Энэ бол яах аргагүй амжилт. Үүнийг хэн ч үгүйсгэж чадахгүй. Манай холбооны бүртгэлийг хүчингүй болгосон учир холбогдох дараагийн байгууллагуудад хандана" гэв.

МҮСБХ, МСБХ-ны хоорондын хэрүүл ийнхүү таван жилийг ардаа үдэв. Хоёр холбооны хэрүүлээс болж Монголын сагсан бөмбөгийн шигшээ багийнхан 2017 онд болох олон улсын тэмцээнд уралдаанд оролцож чадахгүй байдалд хүрч болзошгүй байдал үүсээд байна.

## Угийн бичгээ хөтөлдөг 700 гаруй хүн бий

З.СОНДОР

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Монголын ураг удам уламжлалын холбоо хамтран үндэсний анхдугаар зөвлөгөөнийг зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын удирдлагууд болон Монголын ураг удам уламжлалын эрдэмтэн, судлаачид оролцсон. Зөвлөгөөний үеэр эрдэмтэд илтгэл тавьж, угийн бичиг хөтлөхийн ач холбогдол, хөтлөх аргачлалын талаар мэдээлэл өгсөн юм. Угийн бичиг есөн үеэр шувтардаг, ясан төрөл буюу эцгийн талаа бүрэн хөтөлсөн удам угсааны бичиг юм. Одоогийн байдлаар манай улсад угийн бичиг хөтөлдөг 700 гаруй хүн бий гэсэн судалгаа байдаг бөгөөд энэ дотор 41 үеэ мэддэг хүн ч байгаа ажээ. Мөн тус холбоо есөн аймаг 147 суманд үйл ажиллагаа явуулж салбар зөвлөлөө байгуулсан байна. Түүнчлэн хөдөө орон нутаг дахь салбараараа дамжуулан ард иргэд, залуу хойч үедээ угийн бичиг хөтлөх ач холбогдол, арга зүйг сургах, түгээн дэлгэрүүлж ажилладаг гэдгийг тус зөвлөгөөнд оролцсон эрдэмтэд онцолж байлаа.

Бидэнд тохиолдсон

ХҮНДХЭН ХӨГТЭЙ ЯВДЛУУД

Б. Золзаяа



Энэ эрчүүд үү

Өнөөдөр найз болон найзынхаа нөхөртэй өдөржин "Sunday", шөнийн захаар явлаа. Нэлээд юм авч явтал манай найз дотуур хувцас авна гэлээ. Тэгээд дотуур хувцасны лангуун дээр очив. Нөхөр нь "Ёооё суух минь" гээд л авсан бараагаа тэврээд худалдагч эгчийн сандал дээр суугаад авлаа. Эмэгтэйчүүд бид ч яахав сурсан зангаараа үзэж үзэж ганц хөхний даруулга авахаар болсон юм. Тэгээд "Хэд вэ" гэтэл "30 мянга" гэж байна. Бид хоорондоо "Өмнө нь хосоороо / дотуур өмдтэйгөө/ 30 мянга гэдэг байсан" гээд л ярив аа. Тэгсэн манай найзын нөхөр нь чимээгүй сууж байснаа "Одоо тэгээд ганцаараа 30 мянга юм уу" гээд гайхаад л асуулаа.

Манай найз: Яах вэ, хайр аа. Гоё байна уу. Авлаа шүү

Нөхөр нь: Хосоор нь ав л даа. Яаж нэг хөхөндөө хоосон явах юм бэ" гэдэг байгаа. Бид гурав ч саваад унячихсан. Ха ха ха. Энэ эрчүүд үү, сэтгэнэ гэж бас л.. ха ха ха